



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

— 2004 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН —

Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс
Утас: (976-11) 313207 Факс: (976-11) 324857 Веб сайт: <http://www.forum.mn>

**ГАРЧИГ****ӨМНӨТГӨЛ
Форумын үйл ажиллагааны чиглэл**

3

ЗАСАГЛАЛ

Мэдээллийн эрх чөлөө	7
Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүрэг	8
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт	11
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	13
Нээлттэй, ил тод төсөв	15
Нутгийн болон төвлөрсөн удирдлага	16
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	17
Эрхзүйн туслалцаа	19
Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх төсөл	22
Мэдээлэл холбооны технологийн бодлого	23
Ил тод байдал	24

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Сүүдэр эдийн засгийн үүрэг	27
Бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй	29
Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж	33

НИЙГМИЙН АСУУДЛУУД

Нийгмийн салбарын хувьчлал	35
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	37
Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга, хэрэгсэл	
Хөгжлийн мэдээллийн төв	40
Телевизийн хөтөлбөр	43
Портал сайт	48
Олон нийтийн хэлэлцүүлэг	52
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	53
Хэвлэн нийтлэл	55

**МОНГОЛЫН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ХҮРЭЭЛЭНГИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН БУСАД ХӨТӨЛБӨР**

Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	58
Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	59
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэг	62
Дорно дорно хөтөлбөр	64

ХАВСРАЛТ

Санхүүгийн тайлан	68
Нээлттэй Нийгэм Форумын Удирдах зөвлөл	78
Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд	79

ӨМНӨТГӨЛ

Монгол орны ардчилсан шинэчлэлийг дэмжих, нээлттэй нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 1996 онд анх байгуулагдан Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн /МНХ/ 2004 онд зохион байгуулалт болон үйл ажиллагааны өөрчлөлт хийлээ. Тус хүрээлэнгийн үндсэн хөтөлбөр Нээлттэй Нийгэм Форум /ННФ/ долдугаар сард бие даасан дотоодын төрийн бус байгууллага болон өргөжсөнөөр МНХ үйл ажиллагаагаа өндөрлөж, залгамж холбоогоо Нээлттэй Нийгэм Форумд шилжүүлэв. МНХ-гийн боловсрол, соёл урлагийн хөтөлбөрүүд Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв, Монголын Урлагийн Зөвлөл зэрэг төрийн бус байгууллага болон бие даасан үйл ажиллагаа явуулж байна. Тэрчлэн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн хөтөлбөрүүд дотоодын холбогдох төрийн бус байгуулагуудад шилжлээ.

Нээлттэй Нийгэм Форум нь МНХ-гийн залгамжлагч болохын хувьд тус хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд анхаарч ирсэн олон асуудал, хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааг үргэлжлүүлж байна. Ардчилсан засаглалын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын асуудлаар иргэдэд мэдээлэл хүргэх, иргэд болон бодлого боловсруулагчдыг холбоход түлхүү анхаарч, хүчин чармайлт гарган ажиллаж ирлээ. Тухайлбал, "Форум ТВ" нэртэй телевизийн ток шоу нэвтрүүлгийг 2004 онд эхлүүлж, улс даяар цацдаг болсон нь нийгэм дэх маргаантай асуудлаар өргөн олныг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлж, иргэдийн оролцоог хангахад чухал ач холбогдолтой болов. Нэгдэн Үндэстний Байгууллага, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны оролцоо, дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форумын Хөгжлийн мэдээллийн төвийг нээн ажиллуулсан нь иргэд бодлогын холбогдолтой мэдээллийг чөлөөтэй авах нэг гол эх сурвалж болж байна. Нээлттэй Нийгэм Форумын монгол, англи хэлээр гардаг www论坛.mn вэб хуудас нь бодлогын холбогдолтой мэдээлэл, судалгаа, шинжилгээний онлайн мэдээллийн тэргүүлэх эх сурвалж болон хөгжиж, нийгмийн тулгамдсан олон асуудлаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг дэмжсэн арга хэмжээ боллоо.

Нээлттэй Нийгэм Форум нь иргэний нийгмийн байгууллагуудыг бэхжүүлэх, бодлого боловсруулах, түүний хэрэгжилтэд мониторинг хийх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үргийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж ирэв. Тухайлбал, мэдээллийн эрх чөлөө, олон нийтийн радио, телевиз, төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалтын холбогдолтой хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон нөлөөллийн бусад үйл ажиллагааг иргэний нийгмийн тодорхой



төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлсэн болно. Мониторингийн үйл ажиллагааны хүрээнд сонгуулийн кампанит ажлын үеэр улстөрийн намын зүгээс төрийн эх үүсвэрийг зүй бусаар ашигласан талаар мэдээ, мэдээлэл цуглуулж, дун шинжилгээ хийсэн иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүллээ.

Эдийн засгийн бодлогын асуудал 2004 онд мөн Форумын анхаарлын төвд байв. Монголын бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа, газрын шинэтгэл, өмч хувьчлалын олон чухал асуудлыг хөгжлийн бодлогод тусгах, улсын төсвийн үйл явцын ил тод байдал, энэ үйл явцад олон нийтийн оролцоог дээшлүүлэх, албан бус салбарын зохицуулалт зэрэг олон асуудлаар хэлэлцүүлэг явуулж, судалгааны ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Жишээ нь, Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар “Байгаль 21” төрийн бус байгууллагын хийсэн газрын шинэтгэлийн мониторингоор газрын хуваарилалтад гарч буй алдаа, дутагдал, газар ашиглалтын байдлыг нарийвчилан судалж, иргэдэд газар олгон хуваарилахдаа эдийн засгийн үр өгөөж, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах үүднээс хандаж, шударгя явуулах талаар бодлогын тодорхой зөвлөмж гаргалаа. Уг төсөл газрын шинэтгэлтэй холбоотой маргаан, анхаарвал зохих гол чухал зүйлийн талаар олон нийт, бодлого боловсруулагчдын ойлголт, хандлагыг тодорхой болгоход тус дөхөм болсноос гадна газрын шинэтгэлийн бодлого, хэрэгжилтийн талаарх мэдээллийн баялаг эх сурвалжийг бий болгов.

Нээлттэй Нийгэм Форумаас боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг нийгмийн салбарын хувьчлалын явцад кейс судалгааг захиалан хийлгэж, хэрэгжүүлэгч болон оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг явууллаа.

МНХ-гийн боловсролын хөтөлбөрүүд 2004 онд боловсролын шинэчлэлийг бодлогын болон хичээлийн анги танхимын түвшинд цаашид гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллав. Шинээр хэрэгжүүлж эхэлсэн сурагчдын сурлагын амжилтын үнэлгээний төсөл нь шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, энэ үндсэн дээр сурагчдын сурлагын амжилтын байдлыг бодитой үнэлж, бусад орныхтай харьцуулах боломжийг боловсролын салбарын удирдах ажилтнуудад олгоход чиглэлээ. 2004 оны сүүлчээр МНХ боловсролын үндэсний болон Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн сүлжээний хүүхэд, залуучуудын хөтөлбөрүүдээ нэгтгэн боловсролын салбарт хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх, боловсролын чанарыг сайжруулах, багш нарыг чадваржуулах, боловсрол дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх эрхэм зорилго бүхий Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг нэртэй бие даасан төрийн бус байгууллагыг шинээр байгууллаа. МНХ-гийн гадаадад оюутан сургах тэтгэлэгт хөтөлбөр нэг жилийн өмнө тус байгууллагаас бие даан гарсан Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төвд шилжиж үйл ажиллагаа нь үргэлжилж байна. Тус төв нь ТОЕФЛ-ийн шалгالت авах, шалгалтад бэлтгэх үйлчилгээ үзүүлэх,

тэтгэлэгт сургалтын үзэсгэлэн яармаг зохион байгуулах, хандивлагчидтай хамtran ажиллах зэргээр санхүүгийн хувьд цаашид тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлэн ажиллаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн сургалтыг сайжруулахын тулд Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн магистрын сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Тус хөтөлбөр нь энэ салбарын шинэчлэлийн хүрээнд багшлах боловсон хүчиний нөөцийг бий болгох, эрдэм шинжилгээний жижиг төсөл хэрэгжүүлэх замаар шинжилгээ, судалгааны хүчин чадлыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Мөн бүх нийтийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй эрүүл мэндийн анхан шатны халамж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажиллагсдад мэдлэг, чадвар олгох давтан сургалтын модулийг шинээр нэвтрүүлэхэд тусалсан байна. Урт хугацаанд тогтвортой ажиллах үүднээс уг хөтөлбөр өмнөх төслүүд дээр амжилттай хамtran ажиллаж байсан Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэгт нэгдлээ.

Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал



ЗАСАГЛАЛ

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэдээллийн эрх чөлөөний эрхзүйн орчинг боловсронгуй болгох, иргэдийн мэдээлэл авах, хүртэх эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

Төслийн хүрээнд “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэвлэл, мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулах, иргэний нийгмийн байгууллагуудаас гаргаж буй санаачилгыг дэмжих зэргээр нөлөө үзүүлэх ажил хэрэгжүүлж, улмаар уг хуулийг батлуулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

2004 оны гуравдугаар сард Азийн Сан, “Глоб Интернейшнл” ТББ-тай хамтран “Мэдээллийн нууцлал ба эрх чөлөө” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг иргэний нийгэм болон судалгааны байгууллага, хэвлэл, мэдээллийн төлөөлөл, төрийн байгууллагын ажилтнуудыг оролцуулан зохион байгууллаа. Семинарын үеэр мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийн үзэл санаа, зохицуулалтыг танилцуулан, хуулийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, ялангуяа уг хуульд харшилдаж буй нууцын тухай хуулиудын талаар хэлэлцүүлэг явуулж, санал бодлоо солилцлоо.

Мэдээллийн эрх чөлөөний хуулийг батлуулах нөлөөллийн үйл ажиллагаанд судлаачдыг оролцуулж, төрийн нууцын тухай хуулийг хөндөн ярилцах зорилгоор гуравдугаар сард Иргэний Боловсролын Төслийн хүрээнд зохион байгуулсан “Хүйтэн дайн ба Монгол Улс” сэдэвт олон улсын семинарт Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүллээ. Энэ семинар хүйтэн дайны түүхийн талаарх судалгааны ажлуудын үр дүнг солилцох, коммунист намын архивуудын эх сурвалжууд, 1989-1991-нд ЗХУ задран унасны дараа нээлттэй болсон эх сурвалжуудаас хуваалцах зорилготой байв. Хүйтэн Дайны Олон Улсын Түүхийн Төсөл, Зэрэгцээ Түүхийн Төслийн мэргэжилтнүүд болон Монголын эрдэмтэд оролцсон болно.

Иргэдийн мэдээлэл олж авах эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ялангуяа бодлого боловсруулагчдад энэхүү хуулийн ач холбогдлын талаарх эх сурвалж болох “Мэдээллийн эрх чөлөө” гарын авлагыг “Глоб Интернейшнл” ТББ-тай хамтран боловсрууллаа. Энэхүү гарын авлага нь төрийн байгууллагаас иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэх арга замын талаарх чухал шаардлагатай, иж бүрэн мэдээллийг хялбар бөгөөд сонирхолтой хэлбэрээр хүргэж, иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх,



улмаар нийгмийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм. Гарын авлагад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Үндсэн хууль, иргэдийн мэдээлэл олж авах эрхийг зохицуулсан бусад хууль эрхзүйн актыг багтаасан юм. Түүнчлэн энэхүү гарын авлага нь мэдээллийн эрх чөлөөний хуулийн төслийг батлуулах иргэний нийгмийн нөлөөлөх үйл ажиллагааны гол хэрэгсэл болох юм.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Парламентын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль болсон 2004 оны хувьд, энэ нь цагаа олсон сэдэв байлаа. Өмнөх сонгуулиудаар хэвлэл, мэдээлэл хэдийгээр сонгуулийн талаарх мэдээллээр хахаж байсан ч Монголд хамгийн нэр хүндтэй, өдөр тутмын таван сонин нь хүртэл тухайн үеийн гол асуудлууд, мөрийн хөтөлбөрийн талаар гажуудуулсан, нэг тийш хэлбийсэн, хязгаарлагдмал мэдээлэл өгч байсан нь Нээлттэй Нийгэм Форумыг энэхүү сэдвийг анхаарахад хүргэсэн юм. Улстөрийн сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийнхэн хэрхэн ажилласан талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, сонгуулийн үйл явцын тухай мэдээлэхэд ёс зүйн хэм хэмжээ нэвтрүүлэн мөрдөх үйл явцыг дэмжихийг зорив.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Сонгуулийн үйл явцыг шударга, бодитой мэдээлэх асуудлаар Нээлттэй Нийгэм Форумаас хэвлэл, мэдээллийн байгууллагууд, улстөрийн намууд, иргэний нийгмийн төлөөлөгчид, мэргэжилтнүүдийн дунд цуврал уулзалт, ярилцлага зохион байгууллаа. Эдгээр уулзалт ярилцлагын үр дүнд хэвлэл, мэдээллийнхний баримтлах ёсзүйн хэм хэмжээг боловсруулах, хэвлэл, мэдээллийн өөрөө удирдах байгууллагын суuriйг тавих талаар тохиролцоонд хүрсэн болно.

“Глоб Интернэшнл” ТББ, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Холбоотой хамтран “Чөлөөт бөгөөд шударга байх нь” төсөл боловсруулан хэрэгжүүлэв. Тэнцвэртэй, бодит сурталчилгаа, мэдээллээр дамжуулан шударга сонгуулийг хөхиүүлэн дэмжих зорилго бүхий энэхүү төслийн хүрээнд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл /МСНЭ/, Монголын Сонины Холбоо (MoCX), Монголын Чөлөөт Сонинуудын Холбоо (МЧСХ)-ны хамтарсан бага хураас 2004 оны “Сонгуулийн үеэр сэтгүүлчдийн дагаж мөрдөх ёсзүйн зарчим”-ыг баталж, туршилтын журмаар сонгуулийн

Ӵýâééýë, ὶ ýäýééýë ॰ºð°ºº °ñ+
ð°äæèæ ááéäàà ÷ ðýððżż
ñáí àë áí çáí ì á ááéäàà ,ñç,éá
áàðèì ðéäðäà ÷éééýñý
àéäàáí ,ñí û ì áðáí èéí
áàéöäjé ááéí à.

сурвалжилга, мэдээллийн талаар нэр дэвшигчид болон сэтгүүлчдийн зүгээс гаргасан гомдлыг шүүх шатнаас өмнө эвлэрүүлэн шийдвэрлэх зорилго бүхий Хэвлэлийн түр цэц байгуулж, түүний дүрэм, бүрэлдэхүүнийг батлан ажиллууллаа. Хэвлэлийн түр цэцийн бүрэлдэхүүнд хоёр хуульч, хэвлэл, мэдээллийн гурван эксперт орсон бөгөөд сонгуулийн үеэр нийт хоёр гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. Туршилтын явцад цэц нь хууль эрхзүйн хувьд зохицуулагдаж, дотоод дүрэм журмыг нь нарийвчилан тодорхойлсон байх зэрэг олон асуудал, шаардлагыг бодит байдалд таньж мэдсэн юм. Төслийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгөх, түүний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаар иргэд, сэтгүүлчдийн ойлголт, хандлагыг судлах зорилгоор “Глоб Интернэшнл” ТББ-аас иргэдийн дунд сонгуулийн кампанит ажлын өмнө, хойно хоёр удаа нийт 500 хүнийг хамарсан судалгаа явууллаа.

Сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаанд хэвлэл, мэдээллийн 30 гаруй байгууллагад ажиллаж буй 200 сэтгүүлчийг хамруулсан нь Монголын нийт сэтгүүлчдийн 10 орчим хувийг эзэлсэн ба энэ нь УИХ-ын сонгуулийн үеэр хамгийн идэвхтэй ажиллаж байсан сэтгүүлчдийг төлөөлж чадсан юм. Судалгаагаар “Сонгуулийн үеэр сэтгүүлчдийн баримтлах ёсзүйн зарчим” батлагдсан болон энэхүү зарчмыг сэтгүүлчид дагаж мөрдөж чадсан эсэх тухай өөрсдийнх нь болон олон нийтийн дүгнэлт, Хэвлэлийн түр цэц ажилласан тухай мэдээлэл сэтгүүлчдэд аль хэр хүрсэн, цаашид мэргэжлийн ёсзүйн зарчмыг ердийн хэм хэмжээ болгоход анхаарах зүйлийн талаарх чиг хандлагыг судалсан болно. Энэ нь зөвхөн тухайн төслийн тухай тандалт бус, харин сэтгүүлчийн ёсзүй, хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар олон нийт, сэтгүүлчдийн дунд хийсэн анхны судалгаа болсноороо шинэлэг юм. Сэтгүүлчийн ёсзүй, хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалтын тухай олон нийт, сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн удирдлагад ойлголт өгч, энэ чиглэлээр анхны туршлага хуримтлуулсанд төслийн гол ач холбогдол оршиж байна.

Түүнчлэн сэтгүүлчдийн эдийн засгийн мэдлэг, уг сэдвээр бичих ур чадварыг дээшлүүлэх зорилгоор АНУ-ын Бодлогын Хэлэлцүүлгийг өрнүүлэх Санаачилга байгууллагатай хамтран “Улс орны хөгжлийн нөөц баялаг, ядуурал” зэрэг сэдвээр сэтгүүлчдэд зориулан сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна. Сургалтад Нобелийн шагналт, нэрт эдийн засагч Жозеф Штиглиц зэрэг томоохон эдийн засагчид илтгэл тавих юм.

Ñõäääéäää á
 õàí ðäääääññäúí
 67.8 ðóóäü í ü ñýðäåñé÷äééäá
 ñí í åööéééí „äýð „ñçéäý
 åäðéí õéäí áæéééäæ
 +ääääääé õýí ýýí äéäí yñýí
 åäéí á. 73.4 ðóóäü í ü
 “ñýðäåñé÷äéí í ýá í àí úä
 äääí áí ñóðòäé÷ééæ
 åäéññäí ” áýæýý.



СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ



Ñi í áðóéèéí
áðää öýi æýýi éé i í í éðöi ðéi áééí
ðjéýüi á i ééö 556 áðää öýi æýý
ðai ðäääæeyý.
Ýäýüd áðää öýi æýýi á
óéñööðééí i ñi óóá ööðééí
'i +ééí ááéðüü i ýäýé
àøéäéäñáí ááéäéäåd áâ+ çäýé
80 öðääü i ü Ñ ÖI ,
20 öðääü i ü Ýö i ði i - Áðä+ééäé
ýäýüé ááéñáí . Öäðééí ööðééí
áééäáí öðää+ áøéäéäñáí
ááééñü 99 öðääü i ü Ñ ÖI - ûi
áðää öýi æýýi ä, i ýä öðääü i ü Ýö
i ði i - Áðä+ééäé ýäñéééí áðää
öýi æýýi ä ñi ñi áð+ ááééí à.

Сонгуулийн
кампанит
ажлын
мониторингийн
тайлангаас

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт дэх авилгалын гол асуудал нь бизнесийн бүлгүүд давуу тал олж авах зорилгоор улстөрийн намуудад хандив өгөх, улмаар өөрийн явцуу ашиг сонирхолд нийцсэн хууль тогтоомж болон бусад шийдвэрийг гаргуулах явдал байдаг. Түүнчлэн улстөрийн намууд төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилдаа ашиглах явдал гардаг. Төрийн эрх барьж буй намууд сонгуулийн кампанит ажилдаа төсвийн хөрөнгө, мөнгийг зарцуулах нь авилгалын хэлбэр бөгөөд сонгуулийн тэгш байх зарчмыг зөрчдөг гэж үзэх үндэстэй.

Сонгуулийн кампанийн санхүүжилтийн авилгалыг бууруулах, тэгш нөхцөл бүхий шударга сонгуулийг дэмжих, эрхзүйн орчин, зохицуулалтын хүрээг боловсронгуй болго замаар сонгуулийн ил тод байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн асуудлаар ажиллаж байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Сонгуульд өрсөлдөх улстөрийн намууд ижил тэгш нөхцөлтэй байх зарчмыг үндэслэн "Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг" төслийг Сонгогчдын Боловсрол Төв болон "Глоб Интернэшнл" ТББ-тай хамтран хэрэгжүүллээ. Мониторингийн олон улсын хамтрагч байгууллага болох Будапештэд төвтэй Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Саначилга байгууллага нь мониторингийн явцад аргачлал, техникийн туслалцаагаар хангасан. Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Хуульзүйн санаачилгын ажилтан Мариана Тривунович болон уг байгууллагын зөвлөх Др.Куентин Рид нар 2004 оны хоёрдугаар сард Монголд ирж, төслийн аргачлалыг олон улсын стандарт, туршлага дээр үндэслэн боловсруулсан юм. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэхийн өмнө төслийн баг Унгарын Будапешт хотноо "Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг хянах нь" сэдэвт бүсийн сургалтад хамрагдав. Латви улсын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийн төсөл хэрэгжүүлж байсан туршлага бүхий Провидус байгууллагын ажилтан Лолита Цигане 2004 оны гуравдугаар сард хүрэлцэн ирж мониторинг хийх аргачлалын гарын авлагыг боловсруулахад туслан сургалт зохион байгуулсан болно.

Мониторингийн хүрээнд сонгуулийн кампанит ажлын хугацаанд 10 аймаг, Улаанбаатар хотын турван дүүрэгт зохиогдсон сонгуулийн арга хэмжээ болон хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг хамруулан, төрийн эх үүсвэрийг урвуулан ашигласан талаар тоо баримт цуглувуулан, санхүүгийн тооцоог



гаргав. Түүнчлэн төрийн эх үүсвэрийг улстөрийн зорилгод ашиглахын серөг үр дагаврын тухай олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор эвхмэл болон зурагт хуудас бэлтгэж тараалаа.

Сонгуулийн кампанит ажлын хугацаанд хоёр удаа хэвлэлийн бага хурал хийж, мониторингийн урьдчилсан дүн мэдээг хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. Эхний хоёр удаагийн явцын тайлангийн дүн мэдээгээр байгууллагын нөөцийн ашиглалт өндөр байсан бол 3, 4 дэх удаагийн явцын тайлангийн үзүүлэлтээр буурсан хэдий ч сонгуулийн кампанийн төгсгөлд хамгийн өндөр төвшинд хүрсэн нь ажиглагдав.

Мониторингийн явцад илэрсэн зөрчил, тулгамдсан асуудлыг дүгнэвэл төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанид ашиглах нь аливаа нэг тодорхой намын буруутай үйлдэл гэхээсээ илүү ийм боломжийг бий болгож буй хууль, эрхзүйн тогтолцооны гажуудлыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, үр дүнтэй хууль, эрхзүйн зохицуулалт, түүний хэрэгжилт байхгүй бол аль ч нам, эвслийн үед төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанидаа урвуулан ашиглах нь давтагдах бололцоотой гэсэн дүгнэлтийг мониторингийн үр дүнд гаргасан.

Мониторингийн үр дүн, дүгнэлт дээр үндэслэн дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- | Сонгуулийн кампанит ажлын санхүүжилттэй холбоотой хуулийн заалтыг тодорхой болгох, төрийн эх үүсвэрийг сонгуулийн кампанит ажилд ашиглах бүх суваг, боломжийг хуулиар хаах, хариуцлагын тогтолцоог сайжруулж хэрэгжилтийг хангах,
 - | Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг төрийн мэдлээс гаргах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хүчтэй болгох,



Сонгуулийн кампанит ажын мониторингийн тайлангаас

‐ Өлжүүлэхийн төслийн хувь нийтийн тухай мэдээллийг
нээлттэй болгож нийтэд хүртэлтэй байлгах, иргэний нийгмийн
хяналтын арга, механизмыг бий болгох.

- I Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тухай мэдээллийг
нээлттэй болгож нийтэд хүртэлтэй байлгах, иргэний нийгмийн
хяналтын арга, механизмыг бий болгох.

Мониторингийн дүнг нэгтгэн боловсруулсан тайланг олон нийт болон
бодлого боловсруулагчдад хүргэж, “2004 оны УИХ-ын сонгуулийн
кампанит ажлын санхүүжилтийн мониторингийн үр дүн, зөвлөмж” уулзалт
ярилцлагыг 2004 оны 12 дугаар сарын 13-нд зохион байгууллаа. Уулзалтаар
мониторингийн үр дүн, зөвлөмжийг УИХ-ын гишүүд, улстөрийн намууд,
судлаачид, ТББ-уудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны
талаар санал солилцлоо. Энэхүү тайлан нь хууль, эрхзүйн орчинг
сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхд нөлөөлөх чухал хэрэгсэл болох юм.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төрийн бус байгууллагуудын цаашдын хөгжил, үйл
ажиллагаанд хараат бус, үр нөлөөтэй байдлыг хангасан
эрхзүйн цогц тогтолцоо нэн чухал байгааг харгалзан
холбогдох эрхзүйн зохицуулалтыг олон улсын жишигт
нийцүүлэн боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг
Нээлттэй Нийгэм Форумаас дэмжин хэрэгжүүлж байна. Энэ
төсөл нь ХЗДХЯ-наас санаачлан боловсруулсан “Ашгийн бус
байгууллагын тухай” хуулийн төсөлтэй нягт уялдаатай юм.
Төрийн бус байгууллагуудын /ТББ/ үйл ажиллагааг
зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоход
техникийн туслалцаа үзүүлэх, энэ үйл явцын ил тод байдлыг
хангах, ялангуяа хуулийн төсөл боловсруулахад ТББ-уудын
оролцоог дэмжихэд энэ төслийн зорилго оршино.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Төслийн хүрээнд ННФ нь ХЗДХЯ-ны санаачлан боловсруулсан “Ашгийн
бус байгууллагын тухай” хуулийн төсөл буюу Төрийн бус байгууллагын /
ТББ/ тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл дээр хамтран ажиллаж
байна. Ялангуяа хуулийн төслийг боловсруулах явцад иргэний нийгмийн
оролцоог нэмэгдүүлэх, санал бодлыг тусгах, хууль боловсруулах, батлах
явцыг ил тод, нээлттэй болгох, улмаар хуулийн төслийн чанарыг
сайжруулах зорилготой ажиллалаа. Хуулийн төслийг олон нийтэд
танилцуулж хэлэлцүүлэх уулзалт ярилцлагыг 2004 оны 12 дугаар сарын
17-нд зохион байгуулан ТББ-уудын санал, шүүмжийг хүлээн авлаа.
Түүнчлэн хуулийн төслийг www.forum.mn болон www.open-government.mn
веб сайтуудад байрлуулан онлайн хэлэлцүүлэг өрнүүлж байна.



Хуулийн төслийг боловсруулах үйл явцад мэдээллийн эх сурвалж болгох, иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, эрхзүйн зохицуулалтын ач холбогдлыг ТББ-ууд, бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх зорилго бүхий "Иргэний нийгмийн байгууллагуудад холбогдох хууль тогтоомж" гарын авлагыг орчуулан хэвлүүлж, ТББ-ууд болон төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй тараалаа. Энэхүү номыг Нью Йорк дах Нээлттэй Нийгэм Хүрээлэн хэвлүүлсэн бөгөөд олон улсын стандарт туршлагыг багтаасан юм.

Иргэний нийгмийн хөгжил, ялангуяа санхүүгийн тогтвортой байдлыг хангах шинэ бодлого, зохицуулалт болох "ТББ-ыг дэмжих нэг хувийн татвар"-ын талаар туршлага хуваалцаж, суралцах зорилгоор Унгар улсын Будапешт хотноо 2004 оны 10 дугаар сарын 17-20-нд болсон семинаарт Ардчиллын Боловсрол Төвийн захирал Г.Ундрал ННФ-ын дэмжлэг, санхүүжүүлэлтээр оролцлоо. Семинарын үр дүнд Зүүн болон Төв Европын орнуудад хэрэгжүүлж буй нэг хувийн татварын зохицуулалтаас суралцаж, Монгол Улсын хүн амын орлогын татварын хуулинд нийт татвараас нэг хувийг ТББ-д шилжүүлэх, ингэснээр ТББ-уудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийх нэмэлт, өөрчлөлтийг боловсруулан ажиллаж байна. Энэхүү татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Ашгийн бус байгууллагын тухай хуулийн төсөлд тусгагдсан.

НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ТӨСӨВ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын төсөв нь төрийн бодлогыг тодорхойлдог хамгийн чухал баримт бичиг байдаг. Төсөв нь татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг учир иргэд түүний зарцуулалтын талаарх шийдвэр, хэрэгжилтийг шууд хянах эрхтэй. Гэтэл Монголд улсын төсвийн үйл явц нь харьцангуй хаалттай, мэдээлэл муутай байсаар байна. Иймд улсын төсвийн талаарх мэдээллийг илүү нээлттэй болгох, энэ үйл явцад иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх боломжийг бурдүүлэх үүднээс энэ төслийг 2004 онд хэрэгжүүлж эхлүүлсэн болно.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

2004 оны нэгдүгээр сард «Төсвийн үйл явц ба 2004 оны төсөв» сэдэвт олон нийтийн уулзалт форумыг Дэлхийн банктай хамтран Монгол Улсад анх удаа зохион байгуулав. Уулзалтад УИХ-ын Төсвийн бодлогын байнгын хороо болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүд, Санхүү, эдийн засгийн сайд, иргэний нийгмийн төлөөлөгчид, хандивлагч байгууллагууд, сэтгүүлчид, судлаачид, иргэд оролцож, төсвийн тухай мэдээллийг нээлттэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг асуудлаар санал бодлоо солилцож, бодитой шийдлүүдэд хүрэв. Тухайлбал, аливаа төсвийн байгууллагын төсвийн талаарх мэдээллийг жирийн иргэд авч үзэж болох ба цаашид ийм төрлийн уулзалтыг тодорхой сэдвээр тогтмол зохион байгуулж байхын ач холбогдлыг Санхүү, эдийн засгийн сайд онцлон тэмдэглэж байв.

Төсвийн нээлттэй байдлын талаарх дэлхийн 36 орныг хамарсан Олон улсын төсвийн байгууллагын судалгаанд Монгол Улс хамрагдсан бөгөөд уг судалгааг Нээлттэй Нийгэм Форум хийж гүйцэтгэсэн болно. Энэ судалгаагаар төсвийн нээлттэй байдлыг тодорхойлох үндсэн шалгууруудыг авч үзэхэд Монгол Улс нэн хангалтгүй гэсэн дүн авав. Судалгааг цаашид шинэчлэн гүйцэтгэхээр төлөвлөж байна. Судалгааны дунд Монгол Улс төсвийн нээлттэй байдлын талаар жилээс жилд ахиц гаргаж байгаа эсэхийг объектив шалгуур үзүүлэлтэд түшиглэн бодитойгоор үнэлэх боломж бүрдэж байгаа юм.

Түүнчлэн 2004 оны 11 дүгээр сард 2005 оны төсвийг УИХ-аар хэлэлцэх үеэр Нээлттэй Нийгэм Форум өөрийн телевизийн хөтөлбөрөөр УИХ, Засгийн газар, иргэний нийгэм, хандивлагчид, иргэдийн төлөөлөгчдийг оролцуулсан ярилцлага зохион байгуулж, төсөвтэй холбоотой тулгамдсан асуудлуудын талаар ярилцсан нь иргэдэд ирэх жилийн төсвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголт өгөхөд тус дэм болов.

Øºñâééí 1 ýýéöödýé ááéäéúí
ðàéäàðð áýéööééí 36 í ðí ûá
ðàí áðñáí 1 ëí õéññí
ðºñâééí ááéäööééäñí
ñóááéäàí á 1 1 í ë Öéñ
ðàí ðàááñáí áºøºø á á
ñóááéäàáá 1 ýýéöödýé 1 ééáý
Öí ðóí õééæ áééýöáýúí
áí éí 1. Ýí ýñóááéäàáí û
ðºñâééí 1 ýýéöödýé ááéäéúí
ðí áí ðóí ééí õ 1 áþý
øàéäööððäðð àâ÷ ½çýöýá
1 1 í ë Öéñ 1 ýí ðàí ááéäðæé
áýñýí áéí ááàá.



Төсвийн мэдээллийг нээлттэй болгох өөр нэг алхам бол Нээлттэй Нийгэм Форумын вэб портал дээр «Төсвийн ажиглагч» буланг байрлуулж, түүнд төсвийн талаарх багц мэдээлэл, тоо баримт, хууль тогтоомж, дүн шинжилгээ, тойм зэрэг материалыг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилготойгоор байнга шинэчлэн үзүүлдэг болов. Ингэснээр эдийн засаг, нийгмийн бодлого нь бизнесийн орчин болон иргэдийн амьжиргаанд хэрхэн нэлөөлөхийг дүгнэсэн мэдээ, мэдээлэлтэй бодлого боловсруулагчид, судлаачид, иргэд байнга танилцах боломжтой болно. Төсвийг нээлттэй болгох, олон нийтийн оролцоог хангах зорилго бүхий үйл ажиллагааг Форум 2005 онд үргэлжлүүлнэ.

НУТГИЙН БА ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГА

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд ажиллаж байсан Засгийн газрууд төвлөрсөн бус тогтолцооны харилцан адилгүй төвшинг туршиж ирсэн. Нээлттэй Нийгэм Форум энэхүү төслийн хүрээнд төвлөрсөн ба нутгийн удирдлагын оновчтой харьцааны асуудлыг хөндөхийг зорьж, олон нийтийг хамарсан өргөн хэлэлцүүлэг өрнүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нутгийн ба төвлөрсөн удирдлагын харьцааны асуудлыг судлах бодлогын судлаачаар Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн дэргэдэх Компьютер, Менежментийн Сургуулийн багш, докторант Л. Лувсанжав шалгарч, судалгааны ажлын үндсэн хэсгээ дуусгалаа. Судалгааны үр дүнд Монгол Улсын Үндсэн Хуулийн хүрээнд төвлөрсөн бус тогтолцоог оновчтой болгох чиглэлээр бодлогын тодорхой хувилбар агуулсан зөвлөмж боловсруулсан юм.

Энэхүү бодлогын судалгаан дээр үндэслэсэн, олон нийтийг хамарсан нээлттэй цуврал уулзалт, ярилцлагыг үндэсний болон орон нутгийн төвшинд 2005 онд зохион байгуулахаар төлөвлөж байна. Түүнчлэн ННФ-аас эрхлэн бэлтгэдэг телевизийн “Форум” хөтөлбөрөөр орон нутгийн засаг захиргааны хуваарийн оновчтой байдал, эрх мэдлийн харьцааны талаар сонирхлын бүлгүүдийг оролцуулсан нэвтрүүлгийг зохион байгуулсан нь олон нийтэд уг асуудлын талаар тодорхой мэдээлэл өгч, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгов.



ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Газрын шинэтгэлийн асуудлаар Нээлттэй Нийгэм Форум 2003 онд эхлүүлсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явууллаа. Тухайлбал, газрын шинэтгэлийн талаар иргэдэд мэдээлэл хүргэх боломжийг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн байгууллага, бие даасан судлаачдаар судалгаа, шинжилгээ хийлгэх, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах үйл ажиллагааг дэмжихж ирлээ.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ. ҮР ДҮН

Газрыг иргэдэл өмчлүүлэх үйл явцаас ажиглахад хууль тогтоомжийн болон хэрэгжүүлэх тогтолцооны боловсронгуй бус байдлаас хамааран 2004 онд газартай холбоотой маргаан эрс нэмэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор газрын шинэтгэлийг хэрэгжүүлэх эрхзүй болон институцийн тогтолцоонд үнэлгээ дүгнэлт өгч, бодлогын төвшний санал шүүмж боловсруулах зорилгоор бодлогын судлаач ажиллуулж, дүгнэлт тайланг боловсрууллаа. Мөн хөдөө аж ахуйн газрыг эдийн засгийн эргэлтэд үр дүнтэй оруулах тухай судалгааг хийж гүйцэтгэв. Дээрх судалгааны дунд иргэд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж сул, татвар, төлбөрийн хэмжээ оновчтой бус, иргэнд бус өрх булд өмчлүүлдэг, газрын асуудал эрхэлсэн төрийн

Áaçqđ ï eáí éo,
açéæåéooåé ñí eáí i ñí é
i åðaaai Ç°ð+eé eóýýöý
ååçqđ ååñáí ååéååé
åæéæåååååé ååéåååé åå
eðþáy á i eí í i eéðéééí
i ñí eóí i ñí é öýí åéóúí
ñí åòí eóí l á i ýåððçxéýö
øåðåðæååðåðåé ååéí á.

“Газрын шинэлгэлийн мониторинг” төслийн тайлангаас



байгууллагын хоорондын уялдаа холбоо муу байгаа зэрэг шалтгаанаас газар өмчлөл удаашралтай байгааг тогтоож, зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын хувилбарыг санал болгосон байна. Эдгээр ажлын үр дүнг олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэх, нөлөөлөх үйл ажиллагааг Нээлттэй Нийгэм Форумын зүгээс үргэлжлүүлж байна.

Газрын шинэтгэлийн хэрэгжилтэд иргэний нийгмийн зүгээс мониторинг хийх уралдаанд «Байгаль-21» төрийн бус байгууллага шалгарч, газар ашиглалтын төрөл тус бүрээр гарч буй зөрчил, маргааны талаарх мэдээллийг санал асуулга, албан болон албан бус мэдээ, ажиглалт зэрэг аргаар цуглуулж, дүн шинжилгээ хийж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон тусгайлсан уулзалт семинар зохион байгуулах замаар олон нийтэд хүргэж байна. Уг ажлын нэгдсэн дүн 2005 оны хоёрдугаар улиралд гарах юм. Одоогоор газар олголт, ашиглалттай холбоотой маргаан зөрчил ихээхэн газар авсан байдал ажиглагдаж буй бөгөөд олон нийтийн оролцоотой хяналтын тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Газрын шинэтгэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг үргэлжлүүлэн Форумын вэб порталд шинэ соргог мэдээлэл, дүн шинжилгээ, статистик баримт зэргийг нэгтгэн байрлуулах, Иргэдэд зориулсан гарын авлагыг түгээх зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

Ñóäàëäääí û äçí à èðäýä
ääçðñä ýäééí çàññééí
ýðäýéöýä í ðóóéäö áí éí í æ
ñóé, öåðåäð, öºéáºðééí
öýí æýý í í á+ñí é áóñ, èðäýí à
áóñ ºðö áçéä °í +éçééæ
ääéäää áí éí í ääçðñí àñóóääë
ýðöýéñýí öºðééí
ääéäööéääñí ðí í ðí í äñí
öýéäää ðí éáí í ñóé áäéäää
çýðýä øäéðäääí àñí ääçàð
°í +éº éééí áäéäääé
öäääøðäéäé áäéäää
ðí áóí í æ, çäééøðé áä+
öýðýäæééýð øäéðäääöäé
áí äéí áñí õäéëäöðñä ñäí àë
áí éäí ñí í áäéí à.

“ Газрын
шинэтгэлийн
мониторинг”
төслийн
тайлангаас

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголын хүн амын дунд ядуу иргэдийн эзлэх хувь өндөр, улмаар тэдгээр хүмүүс гэмт хэрэгт холбогдсон үед өмгөөлөгч авах боломж хомс байгаа тул төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй юм. Хуулийн хэрэгжилт, туслалцаа үзүүлэх ажлын уялдаа сул, санхүүжилт хомс зэрэг олон шалтгаанаас үүдэн төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх нь тулгамдсан асуудал болж байна. Иймээс төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүлэн ХЭДХЯ-тай хамтран ажиллаж буйн зэрэгцээ Будапештэд төвтэй “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагатай хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа” төслийг хэрэгжүүлж байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

“Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрхзүйн туслалцаа” төслийн хүрээнд нийгмийн ядуу хэсэгт үзүүлэх эрхзүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний тогтолцоог шинэчлэх санал боловсруулах Ажлын хэсгийг ХЭДХЯ-наас байгуулсан ба “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан үндэсний тогтолцоог бий болгох; тэдэнд хуульзүйн туслалцаа үзүүлэх бодлого хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөл байгуулах; өмгөөллийн туслалцааны төвүүдийг үндэсний хэмжээнд байгуулах; эрхзүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, төрийн бус байгууллагууд, хуульзүйн клиникуудийн үйл ажиллагааг дэмжин хуульзүйн туслалцааны үндэсний тогтолцоотой уялдааг хангах; орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагaa, хуульзүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор паралегалын үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа багтаж байгаа юм.

Эрхзүйн туслалцаа үзүүлэх шинэ загварыг туршихаар Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвийг Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймагт 2004 оны тавдугаар сард байгуулж ажиллууллаа. Энэхүү төвүүд нь ННФ-ын шууд удирдлага, зохион байгуулалтын дор ажиллаж байгаа юм. Төвийн зорилго нь эрхзүйн туслалцааны тогтолцооны шинэтгэлийн үзэл баримтлалыг гаргах, эрүүгийн хэрэг дэх эрхзүйн туслалцааны бүтэц, зохион байгуулалт, удирдлага, үнэ



төлбөргүй туслалцаа үзүүлэх арга механизмыг гаргахад загвар болон тоон мэдээллээр хангах явдал юм. Энэхүү төвүүдэд гэмт хэрэгт сэжиглэгдэж буй бөгөөд өмгөөлөгч авах санхүүгийн чадваргүй хүмүүст эрүүгийн эрхзүйн туслалцааг орон тооны өмгөөлгчид үнэ төлбөргүй хүргэж байна.

Төвүүд нээгдснээс хойших найман сарын хугацаанд нийт 416 эрүүгийн хэрэг хүлээн авч төлбөрийн чадваргүй хүмүүсийн 191 хэргийг шийдвэрлээд байна. Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд нийт 761 хэрэг байгаагас СХД-ийн туршилтын төв нь 22 хувь буюу 169 хэрэг дээр ажилласан бөгөөд шүүхийн шатанд байгаа нийт 190 хэргийн 45 хувь буюу 105 хэргийг шийдвэрлэсэн байна. Хэнтий аймгийн төв нь шүүхийн нийт хэргийн 42 хувь, хэрэг бүртгэлийн 20 хувьд нь өмгөөлөгчөөр оролцсон. Төвийн нийт өмгөөлсөн хэргийн 60 гаруй хувьд нь хориоос бусад ял шийтгэл оноосон байна. Туршилтын төв нь үйлчлүүлэгчийг аль болох түвэг чирэгдэлгүй, чанартай түргэн шуурхай өмгөөллөөр хангах зорилготой. Үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүйг тодорхойлоходоо, заавал баг, хорооны Засаг даргын тодорхойлолт шаардахгүй бөгөөд тусгай сорилын маягтыг ашигладаг шинэлэг үйл ажиллагааг нэвтрүүлсэн.

2004 оны гуравдугаар сард Эрхзүйн туслалцааны төвүүдийн өмгөөлөгчдөд зориулан турван өдрийн сургалт зохион байгуулж, АНУ-ын Шинэ Мексик мужийн Улсын өмгөөллийн газрын өмгөөлөгч Роберт Кинней, Будапешт дахь “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагын ажилтан Надежда Хриптивши нар АНУ болон Зүүн Европын орнууд дахь Улсын өмгөөллийн газар ажиллуулах туршлага, практикаас танилцууллаа. Түүнчлэн төвүүдийн өмгөөлөгчидтэй АНУ-ын Техас мужийн Улсын өмгөөлөгчийн газрын ахлах өмгөөлөгч Елизабет Рожерс нэг сарын хугацаанд ажиллан ур чадвар, менежмент, зохион байгуулалт, үйл ажиллагааны арга туршлагаасаа заан сургаллаа.



Ажлын хэсгээс боловсруулсан “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг нийтэд танилцуулан, санал шүүмж авах зорилгоор “Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн

0°âèéí çî ðèëäâ í ü
ýððçééí ööñéàëöâàí û
øí áòi ëòí í í û
øééí ýðáyééééí Ɂçýé
áàðèí öéâéñâ áàðâàð,
ýððçééí ööñéàëöâàí û
áçýöö, çí õèí í áæéåööéäö,
öäéðâäâàâ, Ɂí ý 0°éá°ðâé
ööñéàëöâà Ɂççéýö àðâà
í áðâí èçí ñâ áðâàðâà
çââââð áí éí í õí í
í ýáyééýð õâí áàð ýâââë
þí .

туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоо” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг 2004 оны 11 дүгээр сарын 15 нд зохион байгууллаа. Дугуй ширээний ярилцлагын үеэр Засгийн газраас төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог шинэчлэх үндэсний хөтөлбөрийн төслийн талаар ярилцаж, бусад улс орны жишгийн тухай мэдээлэл солилцон, өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвийн үйл ажиллагааг танилцуулсан байна.

ННФ-аас орон нутагт эрхзүйн боловсрол, мэдээлэл, зөвлөгөө лавлагааны тогтолцоог боловсронгуй болгох үүднээс “Эрхзүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь” төслийг эхлүүлж байна. Төслийн зорилго нь анхан шатны эрхзүйн зөвлөгөө ба эрхзүйн боловсролыг хөдөө орон нутгийн хүн амд хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал, чадавхийг сайжруулах, үйлчилгээг институтчлан хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэхэд оршиж байгаа болно.

Нээлттэй Нийгэм Форум хүний эрхийг дэмжих, хамгаалах, түгээх, ялангуяа эрхзүйн туслалцаа үзүүлэх албан бус буюу ТББ-ын чадавхийг бэхжүүлэх төсөл дээр АНУ-д төвтэй “Глобал Райтс” олон улсын байгууллагатай хамtran ажиллаж байна. Энэ хүрээнд 2004 оны 10 дугаар сард хүний эрхийн ТББ-уудын үйл ажиллагаандaa хэрэглэж буй арга техник, стратегийг тодорхойлох зорилготой хүний эрхийн стратегийн нөлөөллийн асуудлаарх семинарыг зохион байгууллаа. Энэ үеэр Монгол Улс дахь хүний эрхийн тэргүүлэх ТББ-ууд туршлага амжилтаасаа хуваалцаж, хүний эрх, хуульзүйн эрхийг таниулах, түгээх үйл ажиллагаандaa хэрэглэсэн стратегийг танилцуулсан юм. Семинарт оролцогчид нь жишээг бүлгээр хэлэлцэн анализ хийж, амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс, бэрхшээлийн талаар үнэлэлт өгөн, цаашид хүний эрх болон хуульзүйн эрхийг хамгаалах, сайжруулахын төлөө хийж буй ажиллагаандaa хэрэглэх тодорхой арга барил, техникийг боловсронгуй болгоход суралцлаа. Семинарын үр дүнд Монгол дахь хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг байгууллага, ажилтнуудын дунд хэлэлцүүлэг хийх, мэдээлэл солилцох, практик туршлага, арга барилаа хуваалцах форум бий болгох анхны алхмыг хийж, ТББ-уудын хуульчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хүний эрхийг баталгаажуулах шинэ стратегийг боловсруулах талаар хамtran ажиллах боломж, нөхцлийг бүрдүүлэх суурийг тавьсан юм.



"АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ХЭВШҮҮЛЭХ" ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсын ялын бодлогыг хүмүүнлэг, зардал багатай болгох, энэ ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хорихоос өөр төрлийн буюу албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлж хэвшүүлэх явдал юм. Уг төсөл Улаанбаатар хотын бүх дүүрэгт хэрэгжиж байна.

Албадан ажил хийлгэх ял нь гэмт хэргийн улмаас учруулсан хор уршгаа ялтан нийгэмдээ нөхөн төлөх, нийгэм хамт олны дунд засран хүмүүжиж гэм буруугаа ухаарах, цаашид нийгэмд бие даан амьдрах чадвартай болох боломжийг бурдуулдэг. Гол давуу тал нь насанд хүрээгүй хүмүүс болон хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэмт хэрэгтэн шоронд хоригдон нийгмээс тасрах, рецедив гэмт хэрэгтнүүдийн нөлөөнд автаж давтан гэмт хэрэг үйлдэх нөхцлөөс урьдчилан сэргийлэх явдал юм. Нөгөө талаар эдийн засгийн хүндрэлтэй байгаа манай улсад нэлээд дарамт авчирдаг шоронгийн өртөг зардлыг хөнгөлөх ач холбогдолтой. Иймээс энэхүү шинэ ял нь нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй эрүүгийн ял шийтгэлийн тогтолцоонд нийгэм, хамт олны оролцоог бурдуулэх шинэ хандлагыг бий болгож буйгаараа онцлог юм. Төслийн зорилго нь хөнгөвтөр гэмт хэрэг анх удаа үйлдсэн болон насанд хүрээгүй гэмт этгээдийг нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх, нийгэмд тустай ажил хийснээр учруулсан гэм хороо төлөх боломжийг бий болгох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хүнд хөнгөнөөс нь үл шалтгаалан тусад нь хорих ёстой гэсэн нийгмийн хандлагыг өөрчлөх явдал болно.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

ННФ нь МННХ-гээс санхүүжүүлэн хэрэгжүүлж байсан "Албадан ажил хийлгэх ялыг хэвшүүлэх" төслийг Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газартай хамтран хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд албадан ажил хийлгэх ял оноох, эдлүүлэх, хянах ажиллагааг явуулах хуулийн байгууллагуудын ажилтнуудыг бэлтгэх, мэдээллээр хангах тогтмол сургалтыг зохион байгуулах, холбогдох судалгаа болон олон нийтэд мэдээллээр үйлчлэх зэрэг ажил хийлзээ. Түүнчлэн ажлаар хангах байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, уг ялаар шийтгэгдсэн хүмүүстэй хэрхэн харьцах, ажиллуулах талаар

зөвлөгөө, сургалт зохион байгуулж байна. Ялтантай ажиллах, нийгэмших, засрал хүмүүжилд нь нөлөөлөх үйл ажиллагааг нийгмийн ажилтнуудын туслалцаатайгаар хэрэгжүүлж, нийгэмд тустай ажлаар хангасан байна. Төслийн үр дүнд энэхүү ялыг шүүхээс оноох практик өргөжиж, түүнийг хэрэгжүүлэх аргачлал, туршлага Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх албанад хуримтлагдаж байна. Энэ ажлын хүрээнд уг ялыг эдлэсэн ялтнууд дахин гэмт хэрэг хийсэн тохиолдол гаралаагүй байгаа нь төслийн нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааны тодорхой үр дүн юм.

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН БОДЛОГО

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэдээллийн холбооны технологи нь Монгол Улсын XXI зууны хөгжлийн үндсэн хурдасгуурын нэг хэмээн үзэж Мэдээлэл холбооны технологи (МХТ)-ийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулж, 2000 онд УИХ-аас Үндэсний МХТ-ийг хөгжүүлэх стратегийг баталсан байна. Өнгөрсөн хугацаанд Нээлттэй Нийгэм Форум мэдээлэл холбооны технологийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд “Мэдээллийн технологийн тухай Монгол Улсын хууль”-ийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, бодлогын судалгаа, анализ хийх ажлыг зохион байгуулсан байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Монгол Улсын Дэд бүтцийн яамнаас санаачилан “Мэдээллийн технологийн тухай Монгол Улсын хууль”-ийн төслийг боловсруулсантай холбогдуулан төслийг цаашид улам боловсронгуй болгох, холбогдох талууд, олон нийтийн санаа бодлыг тусгахад дэмжлэг үзүүлэх үүднээс төр, иргэний нийгэм, хувийн хөвшлийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулах, санхүүжүүлэхэд Нээлттэй Нийгэм Форум дэмжлэг үзүүллээ. Ажлын хэсгээс нийт зургаан удаа цуврал уулзалт, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Хуулийн төсөлд задлан шинжилгээ хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэх ажлыг Дэд бүтцийн яам, “МИДАС” ТББ-тай хамtran зохион байгууллаа.

2004 оноос мэдээлэл, холбооны технологийн салбарын бодлогын тулгамдсан асуудлаар судалгаа, шинжилгээ хийлгэх, бодлогын судлаач бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Будапешт дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Мэдээллийн хөтөлбөртэй хамtran Форумын тэтгэлэгт



хөтөлбөрийн хүрээнд дараахь хоёр чиглэлээр бодлогын судлаач ажиллуулж байна. Үүнд:

- | Мэдээллийн эрх чөлөө ба мэдээлэл холбооны технологийн боломж
- | Хөдөө орон нутаг дахь мэдээлэл холбооны технологийн хөгжлийн асуудал

ИЛ ТОД БАЙДАЛ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн хүрээнд бүх төвшинд ил тод байдлыг нэмэгдүүлэх эрхэйн тогтолцоо, үр нэлөөтэй хэрэгжилтийн талаар бодлогын анализ судалгаа явуулах, эх сурвалжийг бий болгох зорилготой.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Авилгалын эсрэг бодлогыг сайжруулахад эх сурвалж, мэдээлэл бий болгох зорилгоор Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Европын Холбоонд Элсэх Үеийн Мониторинг” хөтөлбөрөөс боловсруулан гаргасан “Европын Холбоонд шинээр элсэн орох орнууд дахь авилгалын байдал ба авилгалын эсрэг бодлого” номыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран орчуулан хэвлүүллээ. Энэхүү ном нь Европын Холбооны авилгалтай тэмцэж буй стандарт туршлага, ялангуяа манайтай ойролцоо байдалтай Зүүн Европын орнууд тус холбоонд элсэхдээ авч хэрэгжүүлсэн бодлогын талаарх дэлгэрэнгүй танилцуулга тайлан бөгөөд бодлого боловсруулагчдад тэдгээр улсын туршлагаас санаа авч, хэрэгжүүлж буй бодлогоо сайжруулахад тус дехөм үзүүлэх зорилго тавьсан болно.

Цаашид ННФ энэхүү тайлангийн судалгааны аргазүй, аргачлал дээр үндэслэн Монгол дахь авилгалын төвшин, тархалт, шалтгаан, эх сурвалжууд, тэрчлэн Монгол Улсын Засгийн газраас авилгалтай тэмцэх бодлого, хууль эрхийн болон бүтэц зохион байгуулалтын асуудал, тэдгээрийг сайжруулахад олон улсын байгууллага, хандивлагчдын зүгээс үзүүлж болох дэмжлэг зэргийг тодорхойлох судалгаа бүхий тайланг боловсруулахаар төлөвлөж байна.

ННФ-аас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэхд дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой сэдвүүдээр иргэдээ зориулсан гарын авлага боловсруулан хэвлэн гаргалаа. Тэдгээрийн нэг болох “Хууль хэрхэн бүтдэг вэ” гарын авлага нь хууль, эрхэзүйн зохицуулалтын нийгэмд гүйцэтгэх үүрэг, хууль батлан гаргах үйл явц,

“О°ðөе́и ўðð ិ ўäëëéä
öðâööéäí àøëéäàð ўäëëäé ិ ü
èðäýäéééí äóí à ö°ðä Ɂë
èðäýð áàéëëüñä Ɂñäýæ
ðýäí èéä öéñö°ðééé
éäýäöäé áí èäí æ áóé ðöé
ð°ðéééí äéäáí à øééí ý÷ëýé
ðééö, ðí èéí àäí ð öööéü
ðí àöñí ិ æ öûðäéæéö
ិ áôáí èçí ûä áðäɁçéýö
øààðäéäàðàé áàééí à”.

“Төрийн
эрх мэдлийг
урвуулан
ашиглажын эсрэг
арга хэмжээ”
сэдэвт
судалгааны
ажлын
дүгнэлтээс.

тэдгээрт иргэдийн оролцох боломжийн тухай чухал шаардлагатай, иж бүрэн мэдээллийг хялбар бөгөөд сонирхолтой хэлбэрээр хүргэж, тухайн асуудлыг зохицуулдаг хууль тогтоомжийн талаарх иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.

2004 оны ННФ-ын бодлогын судалгааны хөтөлбөрийн хүрээний сэдэв болох “Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ” бодлогын судалгааны ажлыг судлаач С.Баяраа гүйцэтгэлээ. Судалгааг Төв Европын Их Сургуулийн багш Даниел Смиловын удирдлага, мэргэжил, аргазүйн зөвлөгөөн дор хийв. Уг судалгаагаар төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах явдал нь иргэдийн дунд төрд үл итгэх байдлыг үүсгэж, тэднийг улс төрийн идэвхгүй болгоод зогсохгүй төр авилгалд автсан гэсэн төсөөллийг бий болгож буй тул төрийн албанда шинэчлэл хийх, холбогдох хууль тогтоомж хэрэгжих механизмыг бүрдүүлэх шаардлага байгааг тодруулж, бодлогын зөвлөмж гаргасан болно.



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО





СҮҮДЭР ЭДИЙН ЗАСГИЙН ҮҮРЭГ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүүдэр эдийн засаг нь Монголын нийгэмд чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэмээн үздэг хэдий ч түүний цар хүрээ, мөн чанарын талаар нарийвчилсан судалгаа, цэгтэй ойлголт өнөө хэр байхгүй байгаагаас үүдэн Нээлттэй Нийгэм Форум 2003 оноос сүүдэр эдийн засгийн хэмжээ, үзүүлэлтүүд, тэдээрт нөлөөлөх татварын болон бусад бодлогын асуудалд судалгаа шинжилгээ хийж эхлүүлснийг 2004 онд үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Албан бус секторын өрхийн түүвэр судалгааг явуулах ажлын хүрээнд түүврийн цар хүрээг тодорхойлох зорилгоор урьдчилсан судалгааг хоёр удаа хийж, үндсэн судалгааны арга хэрэгслийг бэлтгэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Тэрчлэн судалгааг гардан хийх тоологч нарын багийг бүрэлдүүлж, тэдэнд зориулан сургалт зохион байгуулав. Ийнхүү үндсэн судалгааг 13900 өрхийг хамруулан есөн аймаг, Улаанбаатар хотод явуулж, судалгааны өгөгдлийг нэгтгэн тусгай программын дагуу дүн шинжилгээ



хийх ажлыг 2004 онд гүйцэтгэлээ. Судалгааны эцсийн дунг 2005 оны эхний улиралд нэгтгэн гаргаж, олон нийтийн хүртээл болгохоор бэлтгэж байна.

Уг судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл хамтран санхүүжүүлж байгаагаас гадна АНУ-ын Мэриландаан Их Сургуулийн "Институцийн шинэтгэл, албан бус секторын төв" зөвлөх үүрэгтэйгээр, Үндэсний Статистикийн Газар хамтрагчаар оролцож байна. Судалгааны аргачлал, үр дүнгийн шинжилгээг хэрхэн хийх талаар судалгааны зөвлөхүүдийн баг Үндэсний Статистикийн Газар, Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл болон Форумын ажилтнуудад зориулан сургалт зохион явуулсан болно.

Судалгааны урьдчилсан дүнгээр Монголд албан бус салбар хүрээгээ ихээхэн тэлсэн ба үүнтэй холбоотой эдийн засаг, нийгмийн шийдвэрлэгдээгүй олон асуудал байгаа нь, тухайлбал уг салбарт ажиллагдын нийгэм, эрүүл мэндийн баталгаа, шударга өрсөлдөөн, татварын оновчтой төвшин, эдийн засгийн газарзүйн болон улирлын хүчин зүйлс зэрэг тулгамдсан асуудал хөндөгдэн гарч ирж байна. Мөн үндэсний тооцооны тогтолцооны хүрээнд албан бус секторын хэмжээг тогтооход шаардагдах шат дараалал бүхий арга хэмжээний зөвлөмжийг боловсруулж байна. Энэ нь цаашид эдийн засгийн хэмжээг үнэн зөв тооцож, улмаар илүү оновчтой бодлого боловсруулахад онцгой ач холбогдолтой байх болно.

Албан бус секторын хэмжээ, бутцэд татварын бодлого хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгааг бодлогын судлаач гүйцэтгэж байгаа ба үр дүн нь 2005 онд гарах болно.

І 11 аа ёа аеёааі аоñ пàеёааð
ð õðýýáý ý èöýýöýí öýëпýí аа
ç ãí ðýé ðí ёаí í ðí é ýäééí
çàñàã, í èéâí èéí
øèéââýðéýââýâé í ëí í
аñóóââæ, ðôðâééââæ õâ
ñâéââðð ñæéééâñâûí
í èéâýí , ýðçéé í ýí àééí
ââðâéââââ, øôââððââ
°ðñ°ëâ°°í, ðâðâââðñí
í í â+ðí é ð°âðèí , ýäééí
çàñââðéí ââçâðççéí áí ëí í
öééðéñí ðç+ðí ççééñí çýðýâ
ðôéââì ãñâí âñóóââæ
ð°í ä°ââ°í ââð÷ èððæ ââééí à.

"Албан бус
секторын
өрхийн түүвэр
судалгаа"-ны
дүгнэлтээс.

БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ИРЭЭДҮЙ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мал аж ахуйн салбар Монголын эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэдэг хэдий ч салбарын хөгжилд нэлээдгүй саад бэрхшээл тулгарсаар гол гол бүтээгдэхүүний гарц буурч, уг салбарыг нуруун дээрээ үүрч явдаг малчдын амьдрал ахуй доройтсоор байгаа юм. Бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй төслийн хүрээнд Нээлттэй Нийгэм Форум нэлээд үйл ажиллагаа төлөвлөн 2003 оны намраас анх хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2004 онд түүний гол гол үр дүн гарлаа.

Засгийн газар болон хандивлагч орнуудын зүгээс тавьж буй хөдөөг хөгжүүлэх хүчин чармайлтууд нь мал маллагааны арга туршлага, орчинг боловсронгуй болгох замаар ядуурлыг бууруулахад түлхүү анхаарч байна. Ийм нөхцөлд Нээлттэй Нийгэм Форум хөдөөгийн иргэдийн амьжиргаа, тэдний сонголт хийх хүрээг өргөжүүлэх зэрэг асуудалд гол анхаарлаа төвлөрүүлж, хэрвээ хөдөөгийн иргэд сонголт хийх өргөн боломжтой бол Монголчууд уламжлалт амьдралын энэ хэв маягаа үргэлж хадгалсаар байх уу, эсвэл амьжиргааны өөр хэлбэрийг сонгох уу, үндэсний хөгжлийн бусад чиг хандлага, дэлхийн эдийн засагт улам бүр татагдан орох шаардлагын талаасаа авч үзвэл хагас нүүдлийн амьдралын хэв маяг тохиromжтой хэвээр байж чадах уу зэрэг сонирхолтой бөгөөд чухал асуултуудад хариулт өгөхийг зорьсон юм.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН


Бэлчээрийн мал аж ахуйн хүрээнд хийгдэж буй аливаа судалгаа шинжилгээ, төслийн бэлтгэл ажлыг хөнгөвчлөх, сүүлийн жилүүдэд дэлхий дахинд бэлчээрийн мал аж ахуйг сонирхон судлах болсонтой холбогдуулан энэ талаарх тал бүрийн мэдээллийн эх сурвалжийг нэг цэгээс авах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх зорилготойгоор Нээлттэй Нийгэм Форум гадаад, дотоодын судлаачид, оюутнууд, шийдвэр гаргагчид, хандивлагч байгууллагууд болон энэ сэдвийг сонирхогч хэн бүхэнд зориулан бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн асуудалтай холбоотой номзүйг боловсруулан гаргасан. Энэхүү номзүйд 1995 оноос хойш бичигдсэн нийт 164 судлаачийн 187 бүтээлийн бүтэц, агуулгыг товч нэгтгэн оруулсан бөгөөд урьд өмнө хийгдэж байсан шинжилгээ судалгааны ном, товхимол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, диссертаци, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлсэн төслийн тайлан, зөвлөмж, тэдгээрийн эх сурвалжууд,

холбогдох бүтээлийн тухай мэдээлэл, дүгнэлтийг олж авах боломжтой. Судалгааны багаас уг номонд орсон бүтээл бүрийн үр дүн, ач холбогдлыг үнэлэх оролдлогыг анх удаа хийсэн болно.

Хөдөөгийн иргэдийн сонголт, амьжиргааны асуудлуудад хариулах үүднээс Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуйн ирээдүйн талаарх санал асуулгыг олон нийтийн дунд явууллаа. Нээлттэй тендерээр шалгарсан “Агро-дэвшил” ТББ-ын бүрдүүлсэн баг энэхүү судалгааг нийт 11 аймгийн 34 сум, Улаанбаатар хотын 21 дүгээр хороог хамруулан салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар малчид, мал аж ахуйн салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн санаа бодлыг судлах зорилгын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар малчдад тулгарч байгаа гол бэрхшээлүүд, тэдний эрэлт хэрэгцээ, хүсэл эрмэлзэл, сэтгэл ханамж, мал аж ахуйн хөгжлийн ирээдүйн талаарх нийгэм дэх хүлээлтуүд зэрэг тодорхой асуудлуудыг нарийвчилан хөндсөн юм.


Энэ судалгааны үр дүн, судлаачдын дэвшүүлсэн санал, зөвлөмжүүд нь бодлого боловсруулагчид, хандивлагч байгууллагууд, судлаачид, сонирхсон хүмүүст чухал ач холбогдолтой бөгөөд судалгааны үр дүнг танилцуулах, хэлэлцүүлэх зорилго бүхий олон нийтийн нээлттэй уулзалт, хэлэлцүүлгийг 2004 оны 9 дүгээр сарын 24-нд эрдэмтэд судлаачид, хандивлагч байгууллагууд, бодлого боловсруулагчид, малчид, иргэдийн дунд зохион байгуулж тэдний санаа бодлыг сонссон байна. Дээр дурдсан судалгааны ажлуудыг англи хэлээр орчуулан нийтэлсэн болно.

Малчдын санааг зовоож буй асуудлууд




**Малчид мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаадаа
хэр зэрэг сэтгэл ханамжтай байна вэ?**
/ Малчдын санал хувиар/

Nóðáæðáðáð á Í àæ+áúí
22.7 ðóðú í ü ¿ð ðóðéyý
°°ðééí áæéñá
cæáñl æéðó í àæ+éí
áí éæí ðní í èððí èðí è áýæ
ðàðéðéñáí 1 ü óýá ¿ð
ðóðéyý í àæ+éí áí éæí ð
ñí í èððí è óðæééø¹ 1 ȝáé
áæéñá 1 ü ðàðáðáðáæ
áæéí à.



Малчдын амьжиргааг сайжруулах талаар хийвэл зохих ажил



Хээлтэй Нийгэм Форумын бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гурван судлаач “Мал аж ахуйд төр, засгийн гүйцэтгэх үүрэг”, “Хөдөөгийн хөгжилд хөгжлийн албан ёсны тусlamжийн үр дүн”, “Мал аж ахуй дахь бодлогын ялгавартай хандлага” гэсэн тодорхой сэдвээр дагнасан судалгаа явууллаа. Энэ сэдвүүдийг тухайн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа гэдгээр сонгосон болно. “Хөдөөгийн хөгжилд хөгжлийн албан ёсны тусlamжийн үр дүн” сэдвийн хүрээнд хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудаас сүүлийн жилүүдэд авсан хөгжлийн албан ёсны тусlamж /ХАЁТ/ нь манай улсын нийт эдийн засаг, хөдөөгийн хөгжилд аль хэр хувь нэмэр оруулсныг судлах, цаашид тусlamж авахад баримтлах бодлогын зөвлөмжийг гаргах зорилготой ажиллалаа. Судалгааны үр дунд үндэслэн хөдөөд, тухайлбал аймгийн төвүүдэд ХАЁТ-ийг нэн түрүүнд юунд чиглүүлбэл зохих талаар санал зөвлөмжийг гаргаснаас гадна ерөөс өнөөгийн бодит байдалт тохиуулан хөгжлийн албан ёсны тусlamж авах бодлого, түүний хэрэгжилт, хяналтын зохицуулалтын хүрээнд авах арга хэмжээний талаар тодорхой санал зөвлөмж дэвшүүлсэн юм.

ХАЁТ-ийн хөдөөтэй холбоотой төсөл, арга хэмжээний эзлэх хувь

	Үнийн дүнгээр Зээл	Буцалтгүй тусламж
Нийт ХАЁТ (сая.ам.доллар)	1255	1221
1991-1993 онд авсан ХАЁТ	269.62	219.96
1994-2002 онд авсан ХАЁТ	985.38	1001.4
Үүнээс хөдөөтэй холбоотой төсөл арга хэмжээнд зарцуулагдсан хувь	58.8%	38.8%

Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд судлаачид судалгааны аргазүй, агуулга, хэрэгжилт дээр дотоод, гадаадын багш удирдагч настай хамтран ажиллалаа. Бодлогын хувилбар, зөвлөмжийг агуулсан баримт бичгийг хамтран боловсруулж, 2004 оны 12 дугаар сарын 10, 15-нд судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэх уулзалтыг зохион байгуулсан. Эдүгээ судлаачид уулзалтын үеэр гарсан санал, шүүмжийн дагуу ажиллаж байна.

Ийнхүү Нээлттэй Нийгэм Форум нь 2004 онд бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй сэдвийн хүрээнд сонирхогч талууд, хандивлагчид, ТББ-үүд, бодлого боловсруулагчид, малчид төдийгүй өргөн олон нийтийг хамруулан судалгаа, санал асуулгын үр дүнгийн талаар харилцан ярилцаж, түүнтэй холбоотой санаа оноог дэвшигүүлэх, санал шүүмжлэл гаргах боломж бололцоог өргөн олон нийтэд бурдуулэхэд анхаарч ажиллалаа.

Судалгааны
үр дүнгээс

МОНГОЛД ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН БАЙГУУЛАХ БОЛОМЖ

Монголд шинээр үүсч буй бизнесийн өсөлтийг хязгаарлаж буй хоёр хүчин зүйл байгаагийн нэг нь боломжийн хүтэй дунд хугацааны зээлийн олдоц, негээ нь зах зээлийн баримжаатай бизнесийн ноу-хауг олж нэвтрүүлэх асуудал юм. Шилжилтийн үйл явцыг ажиглагч, дэмжигчид Монголд дотоодын хувийн хөрөнгө оруулалтын бағавтар сан байгуулах орчин, нөхцөл бүрдсэн байж болох талаар санал нэгтэй болжээ. Ийм сан нь хөрөнгө оруулагчдынхаа ашиг, орлогын төлөө ажиллахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын өмнө хийж гүйцэтгэх ажил, хөрөнгө оруулалттай компанийд бизнесийн үйл ажиллагааны шилдэг арга, туршлагыг түгээх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг.

Нээлтэй Нийгэм Форум 2004 оны есдүгээр сарын 13-наас 10 дугаар сарын 16-ны хооронд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй “Эдийн засгийн бодлогын шинчлэл, өрсөлдөх чадвар” төсөлтэй хамтран хөрөнгө оруулагчдынхаа ашиг орлогын төлөө ажиллах дотоодын хувийн хөрөнгө оруулалтын сан, түүний түвш болох тэтгэлэгээр санхүүжих техник туслалцааны сан байгуулах бодит боломжийг үнэлэх эхний судалгааг явууллаа. Судалгааны зорилго нь (а) цаашид өргөжин хөгжих боломжтой, уг санд хангалттай хэмжээний өгөөж өгөх хөрөнгө оруулалт, түүнтэй төстэй үйл ажиллагаанаас үр ашиг хүртэж чадахуйц хангалттай тооны пүс, компани байгаа эсэх, (б) дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлын төвшин, (в) хэрэв боломжит хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулагчдын сонирхлын талаар олж мэдсэн зүйлс нь зэрэг байвал дэмжлэг авахаар сонгогдсон компани, пүссүүдэд хувийн хөрөнгө оруулалт хийхэд бэлтгэх, гүйлгээний бүтцийг боловсронгуй болгох, сангийн хөрөнгө оруулалтыг удирдан чиглүүлэх, хөрөнгө оруулалт хийсэн компаниудад хөрөнгө оруулалтаа буцаан татах стратегиа боловсруулахад туслалцаа үзүүлэх боломж болон сонирхолтой хандивлагчид, олон улсын санхүүгийн байгууллагууд байгаа эсэх зэрэг асуултуудад хариу өгөх явдал байлаа. Судалгаанд нийт тавь гаруй аж ахуйн нэгж, Олон улсын санхүүгийн байгууллага /ОУСБ/, ТББ, хувийн хэвшилийн сонирхогч бусад байгууллага хамрагдсан болно.

Судалгааны нааштай үр дүнд үндэслэн Монголд хувийн хөрөнгийн оруулалтын сангийн венчар менежментийн компани байгуулахыг судалгааны баг зөвлөсөн бөгөөд цаашид хоёр дах шатны санхүүгийн нарийвчилсан судалгаа хийх зайлшгүй шаардлага байгааг тодорхойлов. Энэ дагуу ажил үргэлжилж байна.

НИЙГМИЙН АСУУДЛУУД



НИЙГМИЙН САЛБАРЫН ХУВЬЧЛАЛ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газраас нийгмийн салбар дахь төрийн өмч, хөрөнгийг хувьчлах, хувьчлалын дараах нийгмийн үндсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлээд байгаа боловч энэ нь нийгмийн үйлчилгээг доголдуулж, өсөлтийг хязгаарлах сөрөг нөлөөтэй байж болох талтай. Үүнтэй холбогдуулан Нээлттэй Нийгэм Форум хувьчлалын бодит явц, гүйцэтгэлийн байдалд хяналт шинжилгээ хийх, хувьчлалын дараах нийгмийн үйлчилгээний нийтлэг жишиг тогтооход чиглэсэн зохицуулалтыг бий болгоход (нийгмийн халамжийн сүлжээ, тэгш хүртээмжтэй байдал гэх мэт) анхаарал хандуулан үйл ажиллагаа явуулж байна.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ ҮР ДҮН

Нээлттэй Нийгэм Форумаас нийгмийн салбарын хувьчлалын талаарх мэдээллийг нийтэд ил тод, хүртээмжтэй болгох, нийгмийн салбарын хувьчлалын зохицуулалтын болон хяналтын механизмуудыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ирлээ. Тухайлбал, энэ чиглэлээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, хувьчлалын үйл явц болон хувьчлалын дараах үйл ажиллагаанд кейс /тухайлсан/ судалгаа явуулж дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулсан байна.

Форумаас кейс судалгаа хийх уралдаант шалгаруулалтыг 2003 оны эцсээр зохион байгуулж, боловсролын салбарт кейс судалгаа явуулахаар "БизМонгол" зөвлөгөө өгөх фирм, эрүүл мэндийн салбарт судалгаа явуулахаар "Эдийн засгийн бодлого судлалын нийгэмлэг" (ЭЗБСН), соёл урлагийн салбарт судалгаа явуулахаар "Төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төв"-ийг тус тус шалгаруулсан юм. Кейс судалгааны ажлын хүрээнд нийгмийн салбарын хувьчлал, шинэтгэлд хамрагдсан байгууллагууд болон холбогдох хууль тогтоомжийг судалж, туршилтын хувьчлалын талаар дүгнэлт өгөхөөр зорьсон болно.

Улмаар 2004 оны нэгдүгээр хагаст багтаан судалгааг салбар тус бүрээр хийж дуусгалаа. Мөн энэ асуудлаар хөндлөнгийн шүүмжүүдийг мэргэжлийн хүрээнд зохион байгуулж, эцсийн тайланг хэвлэж, номын сан болон бусад гадаад дотоодын байгууллагуудад тараалаа. Кейс судалгаанудын үр дүнг англи, монгол хэлээр Форумын вэб сайт дээр байрлуулсан юм.

Боловсролын салбарын кейс судалгааны хүрээнд энэ салбарын хувьчлал, Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургууль, Улаанбаатар Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, хүүхдийн зуслангуудын хувьчлалыг нарийвчлан судалж, баримтжуулж, ололт амжилт, алдаа дутагдлыг

Ай өй әнðт өйн ңаæææðñí
ððаü+ææ í ü °í á°ðñ°í
ððаæöðæ ã ðýæéæýð
ððаü+ææ ãæéæððææð
ææñææð ãæððææð + ðéññí
ðýï æyýï өé í ýäñýï ,
ðï ãðãï ððï é ïððæðææðé,
ðððñðæ ãðé ððñææ ãæéææð
ðýæ ëðñýï í ü ñðæææðæ ãæñ
ðððææææ ãæéí à.

"Боловсролын
салбарын
өөрчлөлт,
шинчлэлт
хувьчлал"
судалгааны
дүнгээс



дүгнэсэн байна. Боловсролын салбарын хувьчлал нь тогтвортой стратегигүй, харьцангуй урсгал байдлаар явж ирсэн нь судалгаанаас харагдаж байна. Жишээ нь Их дээд сургуулиудын хувьчлалыг харилцан адилгүй стратеги баримтлан явуулж, Засгийн газар солигдоход хувьчлалын бодлого өөрчлөгддөг, үнэ төлбөргүй хувьчлал нь төлбөртэй болсон зэрэг тогтвортгүй байдал харагдсан байна. Мөн Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийн хувьчлал бэлтгэл муутай хийгдсэнээс хуульзүйн талаасаа мухардмалд орж, өмч шилжсэн эсэх нь ч тодорхойгүй байдалд оржээ. Хүүхдийн зуслангуудыг хувьчлахдаа зарим нэг процедурын алдаа гаргаснаас иргэдийн дунд үл итгэх, эргэлзэх уур амьсгал бий болсон байна.

Эрүүл мэндийн салбарын хувьчлалын хүрээнд Монголэмимпекс компани, Эмийн үйлдвэр компани, Баянзүрх дүүргийн эмнэлгийг хувьчлах үйл явц, үр дүнг кейсээр судалсан байна. Судалгаагаар эрүүл мэндийн салбарын хувьчлалаар хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар өрсөлдөөний орчинд чанар, хүртээмжийг сайжруулах үндсэн зорилго муу хэрэгжиж байгааг анхааруулсан байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын ерөнхий үйлчилгээнд хамаарах, аж ахуйн тооцоон дээр ажилладаг хэсэгт хувийн салбар түлхүү нэвтрэсэн ч эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үйлчилгээг хувьчлах тухайд ахиц гараагүйг тогтоосон байна. Эмийн үйлдвэрлэлийн салбар, эмийн түгээлтийн салбарын хувьчлалыг хийхдээ салбар бүрийн онцлогт тохируулсан цогц бодлого хэрэгжүүлэгүйн улмаас эрүүл мэндийн үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмж буурч болзошгүй гэсэн үр дүн гарчээ. Улмаар хэрэглэгчдийн эрх ашгийг ноцтой зөрчих нь түгээмэл болсныг тогтоож, авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулсан байна.

Соёл, урлагийн салбарын хувьчлалын хууль, эрхзүйн орчин, хөдөө орон нутаг дахь хэрэгжилт болон Хүүхэд залуучуудын театрны менежментийн хувьчлалын кейс судалгааг хийсэн байна. Соёл, урлагийн байгууллагуудыг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэх бодлого, зохицуулалтын механизм дутагдалтай, салбарын хувьчлалын талаарх эрхзүйн актуудыг олон нийтийн хэлэлцүүлэг, зөвшшилцөлгүйгээр боловсруулан хэрэгжүүлж байгаагаас туршилтын явцад бодлого алдагдсан нь судалгаагаар тогтоогджээ. Тухайлбал, Хүүхэд залуучуудын театрны хувьчлал нь анх хамт олонд нь менежментийн хувьчлалаар өгөхөөр эхэлсэн ч явцын дунд нэг хүнд худалдах хэлбэр тийш хазайсан байна.

Судалгааны үр дүнгийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг салбар тус бүрээр зохион байгуулж, нийгмийн салбарын хувьчлалын сургамж, алдаа оноог дүгнэн цэгнэхийн зэрэгцээ тулгамдсан асуудлыг хэлэлцлээ. Хэлэлцүүлгийн үр дүнг ННФ-ын вэб байтад байрлуулж нийтийн хүртээл болгов. Олон нийтийн хэлэлцүүлгээс салбар тус бүрт зориулан зөвлөмж гаргах нь зүйтэй гэж үзсэн тул холбогдох бодлогын судалгааг хийж, зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна.

Ноёнхөөлжилж, үйлчилгээний үзүүлэлтээсээ хувьчлалыг харилцан адилгүй стратеги баримтлан явуулж, Засгийн газар солигдоход хувьчлалын бодлого өөрчлөгддөг, үнэ төлбөргүй хувьчлал нь төлбөртэй болсон зэрэг тогтвортгүй байдал харагдсан байна. Мөн Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийн хувьчлал бэлтгэл муутай хийгдсэнээс хуульзүйн талаасаа мухардмалд орж, өмч шилжсэн эсэх нь ч тодорхойгүй байдалд оржээ. Хүүхдийн зуслангуудыг хувьчлахдаа зарим нэг процедурын алдаа гаргаснаас иргэдийн дунд үл итгэх, эргэлзэх уур амьсгал бий болсон байна.

"Эрүүл мэндийн салбарын өөрчлөлт, шинчлэлт, хувьчлал" судалгааны дүгнэлтээс

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН СУДАЛГАА

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах нь зах зээлийн эдийн засаг, төвлөрсөн бус удирдлагад шилжээд удаагүй байгаа манай орны хувьд чухал ач холбогдолтой асуудал юм. Манай улсын төвлөрсөн төсвөөс боловсролд зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ нь шилжилтийн эдийн засагтай бусад орныхоос өндөр байгаа төдийгүй жилээс жилд улам нэмэгдсээр буй хэрнээ боловсролын байгууллагын үйлчилгээний чанар, үр өгөөж сайжрахгүй байна гэсэн шүүмжлэл байнга гарсаар байна. Иймээс энэ салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг судлан, бодлогын болон хяналтын төвшинд сайжруулах асуудлуудыг тодорхойлох шаардлага нэгэнт бий болжээ.

Нээлттэй Нийгэм Форум нь Дэлхийн Банктай хамтран боловсролын салбарын төсвийн зарцуулалтын судалгааг 2004 оны 11дүгээр сараас эхлэн 10 сарын хугацаанд хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Төрийн үйлчилгээний нийлүүлэлтийн талыг судалдаг энэ судалгааны аргачлалыг Дэлхийн Банк боловсруулан гаргасан бөгөөд одоогоор 10 гаруй оронд хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнд хүрээд байгаа юм.

Нээлттэй Нийгэм Форумаас энэ судалгааг Монголын боловсролын салбарт хийхээр төлөвлөхдөө дараах үндсэн зорилгыг тавьж байна. Үүнд:

1. Төсвийн талаар найдвартай мэдээлэл цуглуулсны үндсэн дээр бодлогын зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх,
2. Боловсролын төсвийн асуудлыг хэлэлцэх, төсвийн холбогдолтой шийдвэр гаргахад тодорхой мэдээлэлтэй оролцоход нь олон нийтэд туслах зэрэг болно.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Боловсролын салбарын төсвийн зарцуулалтын энэхүү судалгаа үндсэндээ 2005 онд хийгдэх бөгөөд 2004 оны хувьд судалгааны бэлтгэл ажлууд хангагдлаа. 2004 оны зургадугаар сард ЮНЕСКО-ийн Олон улсын Боловсрол Төлөвлөлтийн институт, Дэлхийн Банкнаас хамтран Камбожи улсад зохион байгуулсан төсвийн зарцуулалтын судалгааны сургалтад Монголын зургаан мэргэжилтнийг оролцууллаа. Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд нь судалгаанд оролцохоос гадна мэдээллийн болоод бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах юм.



Боловсролын салбарын удирдах ажилтнууд, эрдэмтэн судлаачид, багш нарын оролцоотойгоор судалгааны зорилго, зорилтыг нарийвчилан тодорхойллоо. 2004 оны 10-12 дугаар сард суурь мэдээллийг бүрдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын зарим ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, багш нар, мөн хоёр дүүргийн Төрийн сангийн мэргэжилтнүүдтэй ярилцлага хийв. Ярилцагуудаар цуглуулсан чанарын мэдээллийг бататгах үүднээс боловсролын байгууллагын санхүүжилт, төсвийн холбогдолтой хууль, журмуудад анализ хийх ажлыг боловсролын экспертуудээр гүйцэтгүүлээд байна. Эдгээр баримт, мэдээлэл дээр үндэслэн судалгаанд ашиглах асуулгыг боловсруулж, 2005 оны нэгдүгээр сарын сүүлийн долоо хоногт Улаанбаатар хотын хоёр сургууль, Дорнод, Ховд, Архангай аймгуудын зургаан сургууль (нийт найман сургууль)-ийг хамруулсан туршилтыг хийлээ.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭРЭГСЭЛ



ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Нээлттэй Нийгэм Форумын Бодлогын Мэдээллийн төв 2004 оны долдугаар сараас эхлэн Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, НҮБ-тай хамтарсан Хөгжлийн Мэдээллийн төв болон өргөжиж үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Тус төв нь Монголын болон дэлхийн бусад орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаарх мэдээллийг нэг цэгээс хүргэдэг, бодлого боловсруулагчид, судлаачид, ТББ-ынхан олон нийттэй уулзаж хөгжлийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлдэг газар болохыг эрхэмлэн зорьж байна.

Хөгжлийн Мэдээллийн төв нь эдийн засгийн хөгжил, бодлогын асуудлаар Засгийн газар, судалгааны болон иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын донор байгууллагуудаас санхүүжүүлсэн төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, үнэлгээний тайлан, бодлогын баримт бичиг зэрэг баримт материалыг хэвлэмэл ба электрон хэлбэрээр үнэ төлбөргүй ашиглуулдаг болно. Мөн сүүлийн үед хэвлэгдэн дэлхий дахинаа нэrd гарч байгаа ном, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, НҮБ-аас эрхлэн гаргасан ном товхимол, статистик мэдээллээр тус төвийн номын сан байнга шинэчлэгдэн баяжиж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Хөгжлийн мэдээллийн төв нь бодлогын асуудлыг сонирхогч хүрээнийхэн, эрдэмтэн судлаачид, сэтгүүлчид, судалгааны ажил хийж буй оюутнууд, улс орны хөгжил, бодлогын асуудлаар мэдээлэл олж авах хүснэлтэй бүх хүнд дараах үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийг зорьж байна.

I Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг

Тус төв нь иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид, зохиогчдод судалгааны ажлын тайлан, хөгжлийн талаар гаргасан ном товхимолоо олон нийтэд танилцуулах, тэдний санал бодлыг сонсох боломж нөхцлөөр хангаж, дэмжлэг үзүүлэх үүднээс уулзалт ярилцлага, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж байна.

Мэдээллийн төвд олон нийтэд зориулсан үйл ажиллагааг 2004 оны 11дүгээр сараас зохион байгуулж эхэллээ. Мэдээллийн төвийг олон нийтэд сурталчилж танилцуулах нээлттэй мэдээллийн өдрүүдийг зохион байгуулсаар судалгааны төв, яам, тамгын газар, УИХ болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, их, дээд сургуулийн багш нар, хэвлэл, мэдээллийн 58 байгууллагын нийт 500 орчим хүн мэдээллийн төвийн



үйл ажиллагаатай танилцсан ба энэ үеэр 700 гаруй ном товхимол үнэгүй тарааж, 35 хүн шинээр уншигчийн карт нээлгүүлж байнгын үйлчлүүлэгч болжээ.

Дэлхийн Банктай хамтран тус Банкнаас хэвлэн гаргасан "Монгол Улсын ойн салбарын тойм", "Монгол орны байгаль орчны мониторинг" судалгааны тайлангийн хэлэлцүүлэг зохион байгуулж байгаль орчны салбарт үйл ажиллагаа явуулдаг ТББ, судлаачид, оюутнууд, БОЯ-ны ажилтнууд зэрэг нийтдээ 70 орчим хүмүүс оролцож санал бодлоо илэрхийллээ.

I Уншлагын танхим, гэрээр ном олгох

Тус төвөөр үйлчлүүлэгчид ном товхимол, баримт бичиг, тогтмол хэвлэлүүдийг уншлагын танхимд болон гэрээр авч үзэх боломжтой. Үүнд:

- Монгол орны хөгжил, нийгэм, улстөр, эдийн засгийн сэдвээр хийгдсэн судалгааны тайлан, салбарын үнэлгээ, бусад баримт бичгийн электрон болон хэвлэмэл хувилбар
- Монгол, англи хэлээр хэвлэгдсэн засаглал, нийгэм, эдийн засгийн асуудлаарх ном
- Өдөр тутмын сонин, Монголын болон гадаадын тогтмол хэвлэлүүд ("Time", "Business Week", "Harvard Business Review", "The Economist" зэрэг сэтгүүл)
- Өдөр тутмын сонины хайчилбарууд (сэдвээр)

2004 онд 250 орчим хүн шинээр уншигчийн карт нээлгэж, 2000 гаруй хүнд үйлчилгээ үзүүлж, 800 гаруй ном товхимол, судалгааны материалыг гэрээр ашигласан ба Интернэт ашиглан мэдээлэл олж авах хүний тоо ч нэлээд нэмэгджээ. Нийт үйлчлүүлэгчдийн 63.2 хувь нь төрийн болон иргэний нийгмийн байгууллагын ажилтнууд, судлаачид байна. Гэрээр болон танхимд ашиглагдаж байгаа материалын 60 орчим хувийг судалгааны тайлан, үнэлгээ эзэлж байгаа юм.

I Электрон каталоги

Мэдээллийн төвд байгаа судалгааны материал, ном, хэвлэмэл баримт, товхимолууд нь хайлтын хялбар систем бүхий онлайн каталоги Lib4U-д бүртгэгдсэн тул Интернэт ашиглан www.forum.mn хаягаар хандан ашигладаг. Одоогоор тус Мэдээллийн төвд 3000 орчим ном, 500 гаруй судалгааны сан бүрджээ.

I Онлайн мэдээллийн сан

Өндөр хурдтай Интернэтд холбогдсон компьютер ашиглан мэдээлэл хайх, судалгаа хийх, тус төвийн судалгааны материалын онлайн хувилбарыг Нээлтэй Нийгэм форумын (www.forum.mn) порталын "Эх сурвалж" гэсэн



хэсгээс PDF форматаар бүрэн эхээр нь татаж үзэх боломжтой. Түүнчлэн Кэмбриджийн онлайн сэтгүүл, Оксфордын лавлах ном, толь бичиг, Дэлхийн Банкны онлайн мэдээллийн сан зэргийг тус төвд сууж үнэ төлбөргүй ашиглах боломжтой. Энэ онд шинээр 200 орчим судалгааны тайлан, үнэлгээ, Засгийн газрын баримт бичиг онлайн мэдээллийн санд нэмэгдэв. 2004 оны 9 сараас эхлэн Төв Европын Их Сургуулийн Бодлогын Мэдээллийн төвтэй (<http://pdc.ceu.hu>) мэдээлэл солилцож эхлээд байна.

I Мэдлэг мэдээлэл түгээх, цуглуулах

Улаанбаатар хотод ажиллаж байгаа мэдээллийн болон судалгааны төвүүдийн дунд мэйлийн групп ажиллуулснаар мэдээлэл солилцох, цуглуулах ажиллагаа хялбар дөхөм болж шинээр гарч байгаа судалгаа, үнэ төлбөргүй тарааж байгаа ном товхимолыг цаг тухайд нь тараах, олж авах боломжтой болов. Одоогоор уг сүлжээнд 11 төв хамрагдсан бөгөөд цаашид нэлээд өргөжих төлөвтэй байна.

Тус төвд ирж байгаа мэдээллүүд нь зөвхөн мэдээлэл, мэдлэг түгээх зорилгоор ашиглагддаг ба тухайн бутээлийн зохиогчийн эрхийг зохиогч болон хамаарлтай байгууллагууд эзэмшдэг юм.

Ийнхүү иргэний нийгмийн байгууллага, хандивлагч байгууллагын хамтарсан анхны мэдээллийн төв байгуулагдан нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаарх өргөн мэдээллийг нэг цэгээс олон нийтэд хүртээмжтэй (онлайн болон номын сангийн үйлчилгээгээр) хүргэж эхэлсэн нь тухайн жилийн гол үр дүн байлаа.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Форумын телевизийн хөтөлбөр нь иргэд, олон нийт, иргэний нийгмийн төлөөлөгчид, бизнесийн хүрээнийхэн, бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчид Монголын нийгмийн тулгамдсан асуудлуудаар телевиз үзэгчдийн өмнө нүүр тulan чөлөөтэй ярилцах, санал бодлоо уралдуулах, мэтгэлцэхэд дөхөм үзүүлэх зорилготой. Телевизийн "Форум" нэвтрүүлгийг Монголын үндэсний телевизээр 2004 оны есдүгээр сараас бэлтгэн явуулж эхэллээ. Нэвтрүүлгийн сэдвүүдийг Нээлттэй Нийгэм Форумын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан сонгож, шинэ чухал сэдвийг иргэний нийгмийн байгууллагууд, иргэд өөрсдөө томьёолж санал болгох бололцоо олгодог. Ток-шоу хэлбэртэй энэхүү нэвтрүүлэгт нэг удаад 35 хүн оролцох боломжтой.

2004 онд нийт 16 нэвтрүүлэг бэлтгэн явууллаа. Эдгээр нэвтрүүлгийг товч танилцуулбал:





1. 2004.09.08.

**"Монгол
дипломны
үнэ цэнэ"**

Монголчууд бүх нийтээрээ дээд боловсролтой болох гэсэн мэт дүр зураг, их дээд сургуулийн захирлууд төгсөгчдийнхөө 70-80 хувийг ажлын байраа олдог гэж мэдэгддэгийн үнэн худал, диплом өвөртөлсөн ажилгүйчүүд яагаад олон байдаг, компанийн захирлууд сайн ажилтан арайхийн олдогийн учир шалтгааны тухай нэвтрүүлэг. Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, багш, оюутан, компанийн захирлууд, хөдөлмөрийн биржийн төлөөлөгчид оролцлоо.

2. 2004.09.15.

**"10.000, 100.000,
500000 эсвэл..."**

2004 оны УИХ-ын сонгуульд оролцсон улстөрийн намуудын 10000, 100000, 500000 төгрөгийн амлалтуудын улстөрийн болоод эдийн засгийн учир шалтгаан, шинээр байгуулагдаж буй Эвслийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ амлалтуудыг тусгах боломжийг улстөрийн намуудын төлөөлөл, эдийн засагчид, иргэд хэлэлцэв. УИХ-ын гишүүн Н.Энхболд, Ж.Батхуяг, Ерөнхий сайдын зөвлөх П.Цагаан, Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн нар оролцлоо

3. 2004.09.22.

**"Улаанбаатар уу,
Утаанбаатар уу?"**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдол экологийн сүйрлийн хэмжээнд ойрхон байгаагийн шалтгаан, энэ асуудлыг шийдвэрлэх арга замуудын тухай нэвтрүүлэг. УИХ-ын гишүүн Т.Бадамжунаай, Байгаль орчны сайд У.Барсболд, дуучин Т.Ариунаа нар оролцов.

4. 2004.09.29.

**"Аймаг, сум, баг:
их цомхотголын
өмнө"**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх асуудлаар улстөрчид, иргэдийн нээлттэй хэлэлцүүлэг. Монголоор нэг тарсан 329 сум, 1500 багийг цөөлж цомхтон цэгцлэхэд улстөрчид юу хийж, олон нийтийн санаа бодлыг хэрхэн бэлтгэх талаар ярилцсан. УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Дамиран, Ерөнхий сайдын зөвлөх Б.Батбаяр, Говьсүмбэр аймгийн иргэн Д.Намжил нарын хүмүүс оролцлоо.

5. 2004.10.06.

**"Иргэд мэддэггүй
Иргэдийн хурал"**

Орон нутгийн сонгуулийн өмнө 2000 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгосон хүмүүсээ иргэд хэр мэддэг талаар ярилцав. Нийслэлийн ИТХ-ын 40 төлөөлөгчийн 30 нь төр, засгийн албан тушаалтан, засаг дарга нар, харьяа байгууллагын дарга, захирлууд байгааг шүүмжилж, дарга нарын хурал уу, иргэдийн хурал уу гэсэн асуулт тавив.

Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Батболд, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Г.Маналжав, иргэн Д.Ламжав нарын хүмүүс оролцов.

6. 2004.10.13.

**"Орон нутгийн
сонгууль: Нэр
дэвшигчдийн**

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид оролцсон телевизийн халз мэтгэлцээний анхны нэвтрүүлэг юм. Эхлээд Чингэлтэй дүүргийн ИТХ-ын сонгуулийн 17-р тойротг нэр дэвшигч Ц.Тунгалаг (МАХН), Я.Гансух ("Эх орон-Ардчилал" эвсэл), дараа нь Нийслэлийн ИТХ-ын 37-р тойротг нэр дэвшигч Э.Ганболд ("Эх орон-Ардчилал"

халз мэтгэлцээн”

эвсэл), А.Отгонболд (МУНН) нар тус тусын дэмжигчдийн хамт шууд нэвтрүүлгийн танхимд хоёр хоёроороо мэтгэлцэв. Нэвтрүүлгийн явцыг Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн, СЕХ-ны гишүүн Р.Бурмаа ажиглаж өөрийн байр сууриа илэрхийлэв.

**7. 2004.10.20.
“Олон нийтийн
радио, телевиз:
Бид бэлэн үү?”**

Монголын Үндэсний радио, телевизийг төр, засгийн болон өөрсдийн хяналтаас гаргаж Олон нийтийн радио, телевиз болгохоор улстериийн хүчинүүд нэгэнт шийдсэн бөгөөд хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхийн өмнө телевиз, радиогийн сэтгүүлчид, уран бүтээлчид энэ өөрчлөлтөд бэлэн үү, олон нийтийн радио, телевиз ямар байх ёстойг мэдэж байна уу гэсэн сэдвийг хөндлөө. Шууд нэвтрүүлэгт УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, МҮТВ-ийн удирдах ажилтан, уран бүтээлчид, хувийн “25-р суваг” телевизийн захирал З.Алтай нар оролцов.

**8. 2004.10.27.
“Зам дээрх
Монгол
амьдрал”**

Улаанбаатар хотод амьдарч буй иргэдийн дийлэнх нь талын нүүдэлчин омгийн сэтгэлгээнээсээ салаагүй, хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцож байгаа хэвшил ийм л ойлголтыг төрүүлж байгааг шүүмжилж, замын хөдөлгөөнд соёлтой оролцож, бие биедээ хүндэтгэлтэй хандаж сурах, үүний тулд иргэд юу хийх, төр, засгийн зүгээс хэрхэн оролцох талаар ярилцав. Нэвтрүүлэгт Замын цагдаагийн газар, Нийслэлийн зам барилга, нийтийн тээвэр хариуцсан байгууллагын удирдах ажилтнууд, жолооч нар оролцво.

**9. 2004.11.03.
“Мянганы
сорилтын
төслүүд:
Дахин нэг
хэлэлцье”**

АНУ-ын Мянганы сорилтын сангаас Монголд буцалтгүй тусlamжаар олгох болсон олон сая долларыг ямар салбар, төсөлд зарцуулбал илүү өгөөжтэй талаар хөндөн ярилцав. Монголчууд энэ мөнгийг авахын тулд олон нийтийн өргөн хэлэлцүүлгийг орон даяар бүсчлэн зохион байгуулж тэргүүлэх ач холбогдолтой төслүүдээ боловсруулсан юм. Нэвтрүүлгээр Мянганы сорилтын сангийн үндэсний зөвлөлөөс дэмжлэг авсан тодорхой төслүүдийг шүүн хэлэлцэв. Шууд нэвтрүүлэгт Мянганы сорилтын сангийн үндэсний зөвлөлийн дарга, Санхүү эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал нар болон төсөл боловсруулж байгаа ажлын хэсгийнхэн, иргэд, бизнесийн төлөөлөгчид оролцов.

**10. 2004.11.10.
“Зээлийн хүү
буурах уу?”**

Банкны салбарынхан, бизнес эрхлэгчид, иргэд, судлаачид зээлийн хүүг хэрхэн бууруулах талаар санал бодлоо хуваалцлаа.

**11. 2004.11.17.
“2005 оны
төсөв:
Бид мэдэх үү?”**

Монгол Улсын 2005 оны төсвийн талаар иргэдэд тодорхой мэдээлэл маш бага, олон нийт, татвар төлөгчид урьдчилан мэддэггүй болохоор төсөв боловсруулахад оролцох, саналаа илэрхийлэх боломжгүй байгаа талаар шүүмжлэн ярилцав. Нэвтрүүлэгт УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Р.Бадамдамдин, УИХ-ын төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга



Г.Занданшатар, МҮЭ-үүдийн холбооны дэд ерөнхийлөгч М.Чимэддорж, Монголын татвар төлөгчдийн холбооны тэргүүн Ж.Уртнасан, Татвар төлөгчдийн ҮЭ-ийн үндэсний холбооны ерөнхийлөгч С.Чулуунбаатар болон багш, судлаачид, иргэд, хэвлэл, мэдээллийнхэн оролцлоо.

**12. 2004.11.24.
“Бид эмнэлэгтээ
итгэдэг үү?”**

Монгол Улсын 10 000 хүнд 27 их эмч, эмнэлгийн 57 дунд мэргэжилтэн ногдож байгаа нь дэлхийн хэмжээгээр тийм ч муу үзүүлэлт биш. Гэтэл жилд дунджаар 30000 хүн гадаадад оношуулж, эмчлүүлэхээр явдаг гэсэн албан бус тоо байдаг. Чухам яагаад, юуны учир монголчууд эрүүл мэндээ гадаадын эмнэлэг, эмч нарт даатгах болсон тухай хэлэлцэв. Нэвтрүүлэгт Улсын клиникийн төв эмнэлэг, Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг, Хавдар судлалын төв, “Нераму” төв, “Ачтан-Элит” клиникийн эмч нар, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш, резидент-эмч нар, иргэд, үйлчлүүлэгчид оролцов.

**13. 2004.12.01.
“Эрчим хүчний
үнэ өссөөр
байх үү?”**

Эрчим хүчний зохицуулах газраас 2005 оны эхнээс эхлэн эрчим хүчний үнийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Үүнтэй холбогдуулан эрчим хүчний үнийг нэмэхээс өөрөөр дотоод зардлаа бууруулах, техникийн болон зүй бус алдагдлыг багасгах гэх мэт арга замаар цахилгаан станцууд болон дамжуулагч, түгээгч компаниуд орлогоо нэмэгдүүлэх бололцоотой эсэх, үнэ нэмэгдсэнээр ард иргэдэд эдийн засгийн ямар дарамт учрах, үнэ нэмэх шийдвэрийг хэрэглэгчид хэрхэн үзэж байгаа талаар хэлэлцлээ. Нэвтрүүлэгт Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүү, эрчим хүчний станцуудын удирдлага, хэрэглэгчид оролцов.

**14. 2004.12.08.
“Шоронгуй ял”**

Монгол Улс ялтныхаа тоогоор дэлхийд тун дээгүүр, 211 улсаас 34-т ордог. Тэр олон хоригдол дотор ял нь хүндэдсэн олон хүн байдаг. Тухайлбал 110 000 төгрөгийн гар утас хулгайлсан нэг хүү 11 жилийн ял авчээ. Энэ жишээнд түшиглэн Эрүүгийн шинэ хуулийн үйлчлэл, ялын бодлого оновчтой байгаа эсэх тухай хөндөв. Энэ нэвтрүүлэгт УИХын гишүүн Л.Шаравдорж, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Г.Баясгалан, шүүгч, өмгөөлөгчид, прокурорууд оролцлоо.

**15. 2004.12.15.
“Бидэнд ямар
нам
хэрэгтэй вэ?”**

Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй улстөрийн 20 намын төрх, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан уг нэвтрүүлгээр Монголын хүн амын талаас илүү хувь нь аль нэг намд гишүүнчлэлтэй боловч нийт иргэдийн 60 хувь улстөрийн намуудад итгэдэггүй талаар баримт түшин ярилцлаа. Нэвтрүүлэгт Ардчилсан намын дарга М.Энхсайхан, Эх орон-МАШСН-ын дарга Б.Эрдэнэбат, улстөр судлаач Д.Ганхуяг, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирал Г.Чулуунбаатар, Иргэний зориг-Бүгд найрамдах намын дэд дарга Ц.Ганхуяг, судлаач Д.Ламжав, Х.Тэмүүжин, Ардчилсан социалист хөдөлгөөний гүйцэтгэх зөвлөлийн дарга А.Ганбаатар нар оролцлоо.

**16. 2004.12.22.
“Монгол хаана
оршдог вэ?”**

Монгол бол дэлхийн хамгийн том эх газрын дундах 1,5 сая хавтгай дөрвөлжин км нутаг. Далайд ямар ч гарцгүй, далай хүртэл 1000-2000 км зйтай. Энэ нэвтрүүлгээр хоёр их хөршийн дунд түгжигдсэн Монголын geopolитикийн асуудлаар мэтгэлцлээ. Нэвтрүүлэгт Монголын geopolitик судлаачид, төрийн бус байгууллагынхан, сонирхогчид, гадаадын иргэд оролцлоо.



"www.forum.mn" ПОРТАЛ САЙТ

"Нээлттэй Нийгэм Форум" портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явцын талаарх мэдээ, мэдээллийг түгээх, улмаар үүндээ тулгуурлан хүмүүсийн санал бодол, олон талт байр суурийг хүлээн авах, тухайн сэдэв, асуудлын хүрээнд сонирхогч олон нийт өөр хоорондоо санал солилцох хэлэлцүүлгийн талбарыг бүрдүүлэх зорилготойгоор 2003 оны 10дугаар сард анх байгуулагдсан. 2004 он бол тус сайтын хувьд үйл ажиллагааныхаа төлөвшлийг олох хамгийн чухал жил байлаа. Монгол, англи хэлээр мэдээллээ түгээдэг энэ сайтын бүрэлдэхүүн хэсгүүдийн агуулга, хэлбэрийг бүрдүүлэхдээ юуны өмнө түргэн шуурхай, шинэлэг, бодитой байх, үл туйлшрах зэрэг орчин цагийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтладаг тулгуур зарчмуудад үндэслэсэн болно. Нийтлэл, бодлогын асуудал, эх сурвалж, хэлэлцүүлэг, ажиглалт зэрэг сайтын үндсэн хэсгүүд энэ хугацаанд өөрийн бүтцээ баталгаажуулсан гэж дүгнэж болох юм. Үүний үр дүнд 2004 онд манай сайтад нийт 170 мянга орчим хэрэглэгч хандсан бөгөөд сард дундажаар 14 мянга орчим хүн нэвтэрч хэрэгцээт мэдээллээ авчээ.

НИЙТЛЭЛ

Портал сайтын олны анхаарлыг татсан нэг чухал хэсэг нь нийтлэл юм. 2004 онд Монголын нийгэм, улстөр, эдийн засаг, хөгжлийн асуудлыг хөндсөн мэдээ мэдээлэл, нийтлэл, өгүүлэл, тойм, ярилцлага зэрэг нийт 132 материалыг олны хүртээл болгожээ. Бичигчид нь Монголын өдөр тутмын сонинуудын сэтгүүлч, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаач, шинжээч голдуу 40 гаруй хүн /давхардсан тоогоор/ байна. Сэдвийн хувьд нарийвчлан авч үзвэл сонгууль, ардчилал, засаглал, хүний эрх, санхүү, мөнгөний бодлого, төсөв, газрын харилцаа, мал аж ахуйн ирээдүй, бүсчилсэн хөгжил, хэвлэл мэдээллийн эрх чөлөө зэрэг асуудлыг түлхүү тусгасан нь өнөөгийн Монголын нийгмийн тулгамдсан асуудлуудыг тодорхой хэмжээгээр илэрхийлсэн гэж үзэж байна.

2004 онд "Орчуулгын нийтлэл" сэдвийн дор гадаадын нэр хүнд бүхий нийтлэлч, сэтгэгчдийн зохиол бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлэн олны хүртээл болгосон нь бас нэг шинэлэг эхлэл боллоо. Одоогоор Жеффри Сакс, Ральф Дарендорф, Людвиг фон Мизес, Жозеф Штиглиц, Жорж Сорос, Фернандо Дэ Сото, Мишел Роше, Милтон Фридман, Дэни Родрик нарын дэлхийд нэр хүндтэй зохиогч, нийтлэлчдийн бүтээл, хэлсэн үг зэргээс орчуулан монгол уншигчдад хүргээд байна.

НИЙТЛЭЛ

Нийт 132. Үүнийг сэдвээр ангилбал:	62
Улс төр	62
Нийгэм эдийн засаг	27
Нийгмийн оюун санааны амьдрал	18
Дэлхий дахин ба гадаад харилцаа	9

БАЙНГЫН АЖИГЛАЛТУУД

Сонгууль – 2004

2004 онд Монгол Улсын хувьд ихээхэн чухал үйл явдал гэж үзэх Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулиуд болсон. Үүнтэй холбогдуулан манай портал “Сонгууль-2004” ажиглалт явууллаа. Энэ ажиглалт нь улстөрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн дүн, нэр дэвшигчид, сонгуулийн кампанит ажлын явцын талаарх бүхий л мэдээ мэдээлэл, улстөрчдийн хэлсэн үг, ярилцлага, намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар эрдэмтэд, судлаачдын шүүмж анализ, төрийн бус байгууллагуудын санал зөвлөмж, сонгуультай холбоотой хууль тогтоомж, өмнөх сонгуулиудын дүн /1992, 1996 оны УИХ-ын сонгууль, 1993, 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудын дүн/ зэрэг уг үйл явцтай холбоотой өргөн хүрээтэй мэдээ материалыг нэг дор байрлуулан, цаг тухай бүрт нь шинэчлэн түргэн шуурхай танилцах боломжийг олон нийтэд бүрдүүлсэн юм. Энэ хүрээнд 2004 онд нийтдээ 444 орчим мэдээ, мэдээллийг нэг дор байрлуулсан нь манай портал сайтын энэ оны хамгийн их мэдээлэл агуулсан хэсэг болжээ.

Сонгуулийн ажиглалт цаашдаа тогтмол үргэлжлэн 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ажиллана. Тэрчлэн парламентын болон орон нутгийн сонгуулийн үр дүнгээр нөхцөлдөн бий болсон УИХ, Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаа, бодлогын талаар тогтмол мэдээлэхийн зэрэгцээ тухайн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд судлаачдаар шүүмж анализ хийлгэн хөндлөнгийн хяналт бий болгоход анхаарч ажиллана. Мөн Монголын улстөрчдийн амлалт, түүний хэрэгжилтийн талаар мэдээлдэг “Хэн юу хэлэв” буланг сонгуулийн ажиглалтын хүрээнд тогтмол ажиллуулахаар төлөвлөөд байна.

“Төсвийн үйл явц”

Улсын төсөв бол Засгийн газрын бодлогыг тодорхойлох үндсэн баримт бичиг байдаг. Иймд тус портал нь жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллүүдийг олон нийтэд тогтмол толилуулахаар болсон юм. Энэ ажлын эхлэл 2004 онд үндсэндээ тавигдаж, 2004 оны төсвийн тодотгол болон 2005 оны төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явцтай холбоотой



СОНГУУЛЬ 2004

Нийт	444
Мэдээ, мэдээлэл	326
Мөрийн хөтөлбөр	3
Сонгуулийн үр дүн	4
Улстөрчдийн хэлсэн үг	26
Шүүмж анализ	47
ТББ-уудын санал	10
Хууль тогтоомж журам	7
Бусад	12
Хэн юу хэлэв	9

мэдээллүүд, тухайлбал, төсөв өрөнхийлөн захирагчдын зарцуулах хөрөнгө, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэг мэдээллийг олон нийтэд хүргэлээ. Энэ ажиглалт цаашид тогтмол үргэлжлэх юм.

“Уул уурхай ба хөгжил”

Улс орны хэмжээнд хөрөнгө оруулалтаар хамгийн өндөрт орж байгаа уул уурхайн салбарын Монгол Улсын хөгжилд оруулж буй төлөв байдалд ажиглалт хийх зорилготой “Уул уурхай ба хөгжил” сэдэвт ажиглалтыг 2004 оны 12 дугаар сарын 20-нд эхлүүллээ. Энэ салбарын талаарх судалгаа, тайлан үнэлгээ, томоохон төслүүд, тэдгээрт холбогдох гэрээ, баримт бичиг, хууль тогтоомж, хэрэгжилтийн тухай баримт мэдээллийг манай портал сайт олон нийтэд тогтмол шуурхай хүргэнэ.

БОДЛОГЫН АСУУДАЛ

Монголын нийгэмд хурцаар тавигдаж буй асуудлууд, парламентаар хэлэлцэн батлуулахаар өргөн баригдсан хуулийн төсөл, баримт бичгүүд, тэдгээртэй холбоотой судалгаа, санал зөвлөмжийг “Бодлогын асуудал” булангаараа багцлан толилуулж, үүнд тулгуурлан олон нийтийн санал бодлыг толилуулах ажлыг зохион байгууллаа.

2004 онд УИХ-ын ажлын хэсэг, Тамгын газартай хамтран “УИХ-ын гишүүний ёсзүйн дүрэм”, “УИХ-ын Ёсзүйн дэд хорооны дүрэм”-ийн төслүүд, “Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн хоёр хувилбар болон Хуульзүй, дотоод хэргийн яам, “Глоб Интернейшнл” ТББ-тай хамтран “Ашгийн төлөө бус байгууллагын тухай”, “Олон нийтийн радио, телевизийн тухай”, “Мэдээллийн эрх чөлөөний тухай” тухай хуулийн төсөл, Санхүү, эдийн засгийн яамтай хамтран “Улсын төсөв”, Мэдээлэл, холбооны технологийн хуулийн төсөл зэрэг долоон асуудлаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

ЭХ СУРВАЛЖ

Порталын мэдээлэл түгээх бас нэгэн чухал хэсэг бол "Эх сурвалж" юм. 2004 онд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвүүдийн сүүлийн 10 жилд хийсэн 300 гаруй судалгааны тайлан, үнэлгээ, бодлогын баримт бичгүүдийг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудын олон нийтэд байнга танилцуулж эхэллээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, САНАЛ АСУУЛГА, ҮЙЛ ЯВДАЛ

Портал сайт нь олон нийтэд тал бүрийн мэдээлэл түгээхийн зэрэгцээ тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2004 онд хэлэлцүүлгийн тасалгаа ажиллуулж эхэлсэн юм. Бодлогын асуудлаар санал бодлоо илэрхийлсэн, улс орны хөгжил дэвшилд түлхэц болохуйц санаа оноогоо сайтад хандагсад илэрхийлэх боллоо. Тухайлбал, 2004 оны зургадугаар сараас эхлэн Монголын эдийн засгийн ирээдүйн дүр төрх, Монголчууд хэзээ таван саяд хүрэх вэ зэрэг сэдвийн дор хэлэлцүүлэг өрнүүллээ. Портал сайтад өдөрт дундажаар 500 орчим хүн нэвтэрч, 50 орчим хүн эдгээр сэдвийн хүрээнд идэвхтэй яриа өрнүүлсэн байна. Нийтдээ 450 орчим хүн санал бодлоо илэрхийлжээ.

Тухайн цаг үед олны анхаарлыг татсан, бодлогын шинжтэй чухал асуудлын талаарх олон түмний санаа бодлыг тандах бичил санал асуулгыг 2004 оноос эхлэн 10-14 хоногийн давтамжтайгаар тогтмол явууллаа. Нийт 31 санал асуулга явуулснаас "Сонгууль чөлөөтэй бөгөөд шударга болсон уу?" хэмээх санал асуулгад хамгийн олон буюу 785 хүн оролцсон байна.

Нээлттэй Нийгэм Форумаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг "Үйл явдал" булан, тус байгууллага болон олон улсын бусад байгууллага, гадаадын их дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээллийг "Зарлал" булангаар тус тус тогтмол мэдээллээ. Энэ хүрээнд 2004 онд нийт 26 орчим үйл явдлын тухай мэдээлэл, уулзалт ярилцлага, сургалт семинарын дэлгэрэнгүй тэмдэглэл, 38 гаруй олон улсын тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээсэн байна.



ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нээлттэй Нийгэм Форум нь бодлого боловсруулах болон түүний хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад иргэдийн идэвхитэй оролцоог дэмжих улстэр, нийгэм, эдийн засаг, хөгжлийн асуудлаар байнга нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

2004 онд нийт 30 гаруй ярилцлага зохион байгуулж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан олон асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулж, цөөнгүй хуулийн төслийн хэлэлцүүлгийг сонирхогч бүхий л талын оролцоотойгоор явууллаа. Тухайн уулзалт, ярилцлага, хэлэлцүүлгийн явцад гарсан санал зөвлөмж, шүүмжлэлийн тэмдэглэлийг www.forum.mn портал сайтаас үзэж болно.

2004 ОНД ЗОХИОН ЯВУУЛСАН ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1	Улсын төсвийн үйл явц, 2004 оны төсвийн онцлог	2004 оны 1-р сарын 15
2	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн төсөл	2004 оны 3-р сарын 12
3	"УИХ-ын гишүүний ёсзүйн дүрэм"-ийн төсөл	2004 оны 3-р сарын 24
4	Сонгуулийг чөлөөтэй бөгөөд шударга мэдээлэх нь I	2004 оны 3-р сарын 29
5	Чөлөөтэй бөгөөд шударга байх нь	2004 оны 4-р сарын 12
6	Сонгуулийг чөлөөтэй бөгөөд шударга мэдээлэх нь II	2004 оны 4-р сарын 14
7	Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг	2004 оны 4-р сарын 23
8	Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх төвийн нээлт	2004 оны 5-р сарын 10
9	Хүн төрөлхтний сайхан ирээдүйг шинжлэх ухааны чадавхиар байгуулах нь	2004 оны 7-р сарын 16
10	Их эвслийн Засгийн Газар, түүний үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	2004 оны 8-р сарын 30
11	Мянганы сорилын сангийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг хангаад хэрхэн үр дүнтэй ашиглах вэ?	2004 оны 9-р сарын 13
12	Монголын мал аж ахуйн ирээдүй: Олон нийтийн санаа бодлыг тандах нь	
13	Хүний эрхийн стратегийн нөлөөлөл, туршлагаас суралцах сургалт	2004 оны 10-р сарын 12
14	Монголд хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж	2004 оны 10-р сарын 13
15	Боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал: кейс судалгаа - үр дүн, сургамж	2004 оны 10-р сарын 14
16	Соёл, урлагийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал: кейс судалгаа - үр дүн, сургамж	2004 оны 10-р сарын 15
17	Эрүүл мэндийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал: кейс судалгаа - үр дүн, сургамж	2004 оны 10-р сарын 25
18	Төлбөрийн чадваргүй иргэдэд эрхзүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоо	2004 оны 11-р сарын 15

19	“Зочны цаг” цуврал лекц: АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Памела Ж. Слуц “Америк-Монголын харилцааны иж бүрэн түншлэл”	2004 оны 12-р сарын 3
20	Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Танер Каракас “Турк-Монголын Харилцаа”	2004 оны 12-р сарын 9
21	Хөдөөгийн хөгжилд хөгжлийн албан ёсны тусlamжийн үр дүн Бодлогын судлаач С.Бат-Оюун	2004 оны 12-р сарын 10
22	2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторингийн үр дүн	2004 оны 12-р сарын 13
23	Мал аж ахуйд төрийн үүрэг Бодлогын судлаач Б.Эрдэнэбаатар	2004 оны 12-р сарын 15
24	Мал аж ахуй дахь бодлогын ялгавартай хандлага Бодлогын судлаач Б.Батбуян	2004 оны 12-р сарын 15
25	Ашгийн бус байгууллагын хуулийн төсөл	2004 оны 12-р сарын 17

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

2003 оны есдүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн Нээлттэй Нийгэм Форумын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр нь бодлогын холбогдолтой асуудлаар иргэдэд чанартай мэдээлэл хүргэх, бодлогын судалгаа, шинжилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, бодлого судлаач, шинжэчдийн чадавхийг хөгжүүлэх, тэднийг олон улсын бодлого судлаачдын нийгэмлэг болон мэргэжилтнүүдтэй холбогдон хамтран ажиллахад тус дөхөм үзүүлэх зорилготой юм.

Бодлогын судалгааны 2004 оны тэтгэлэгт хөтөлбөрт нийт 9 судлаач шалгаран хамрагдаж, нэгээс бусад нь судалгааны ажлаа үндсэндээ дуусгаад байна.

Үүнд:

Б.Батбуян

Мал маллагааны бизнесийн эдийн засаг

Ц.Батхишиг

Газрын шинэтгэлийн эдийн засаг

Б.Бат-Оюун

Хөдөөгийн хөгжилд хандивлагчдын зүгээс

С.Баяраа

үзүүлж буй туслалцааны үр нөлөө

Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын

эсрэг авах арга хэмжээ



Р.Бурмаа	Улстөрийн кампанит ажлын санхүүгийн зохицуулалт
Б.Энхбайгаль	Татварын бодлого ба сүүдрийн эдийн засаг
Б.Эрдэнэбаатар	Мал аж ахуйн салбарт төрийн гүйцэтгэх үүрэг
Р.Ганхуяг	Газрын шинэтгэлийн эрх зүйн болон бүтцийн хүрээ
Л.Лувсанжамц	Төв, орон нутгийн засаг захиргааны зохистой тэнцвэр

Мөн мэдээллийн эрх чөлөө ба мэдээлэл холбооны технологийн боломж, хөдөө орон нутаг дахь мэдээлэл холбооны технологийн хөгжлийн асуудал зэрэг сэдвээр 2004 оны 10 дугаар сард хоёр судлаачийг шалгаруулан ажлыг нь эхлүүлээд байна. Үүнд:

Ц. Нямхүү	Мэдээллийн эрх чөлөө ба мэдээлэл холбооны технологийн боломж
Т.Наранмандах	Хөдөө орон нутаг дахь мэдээлэл холбооны технологийн хөгжил

Судлаачаар шалгарсан хүмүүст зориулан бодлогын судалгаа, шинжилгээний арга зүйн цуврал сургалт зохион байгуулах, судалгааны ажилд нь олон улсын болон дотоодын мэргэжилтнүүдээр зөвлөгөө өгүүлэх, тэтгэлэг олгох зэрэг дэмжлэг үзүүлж байна.

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Иргэдийн зүгээс бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад оролцох ўйл явцыг мэдээллээр хангах, бодлогын судалгаа, шинжилгээний ач холбогдол, чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилго, чиглэл бүхий дараах хэлбэрийн ном товхимолыг ННФ-аас эрхлэн нийтэлж, олон нийтэд түгээж байна.

1. ГАРЫН АВЛАГА

Иргэдэд зориулсан гарын авлага, хөтөч нь тухайн сэдвээр иргэдэд нэн чухал шаардлагатай, иж бүрэн мэдээллийг хялбар дөхөм, сонирхолтой хэлбэрээр хүргэж, тухайн асуудлыг зохицуулдаг хууль тогтоомж, тодорхой жишээ кейс, зураг дүрс, хүснэгт зэргийг агуулдаг юм. 2004 онд нийт таван бүтээл хэвлэгдэн гарлаа. Үүнд:

- Газрын харилцааны шинэтгэл
- Хууль хэрхэн бүтдэг вэ?
- ТББ ба Татвар
- Иргэн ба Татвар
- Мэдээллийн эрх чөлөө

2. НОМЗҮЙН ЦУВРАЛ

Нээлттэй Нийгэм Форум нь ўйл ажиллагааныхаа чиглэл бүрт холбогдох бүхий л эх сурвалжийг аль болох багтаасан номзүйн цуврал гаргаж, тухайн сэдвээр судалгаа хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтнууд, оюутан сурагчид, бодлого боловсруулагчид, хандивлагчид, сонирхсон хэн бүхэнд хүргэхийг зорьж байна. 2004 онд

- Монголын бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн холбогдолтой номзүй
- Монгол дахь ядуурлын асуудалтай холбогдох номзүйг тус тус гаралаа.

3. БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Форумаас эрхлэн гүйцэтгэсэн болон санхүүжүүлсэн судалгааны болон мониторингийн тайлан, бодлогын судлаачдын бүтээлийг тусгайлан хэвлэж нийтийн хүртээл болгож байна. Үүнд:

- Монголын бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй: Олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа.
- Нийгмийн салбарын хувьчлал: Боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал, кейс судалгаа.
- Нийгмийн салбарын хувьчлал: Соёл урлагийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал, кейс судалгаа.
- Нийгмийн салбарын хувьчлал: Эрүүл мэндийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал, кейс судалгаа.



4.ЛАВЛАГААНЫ ЦУВРАЛ

Нийгэм, эдийн засаг, улстөр, эрхзүйн шинэтгэлийн асуудлаар оновчтой бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тус дэхем үзүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглүүлэн олон улсын төвшний мэдлэг, туршлагыг тоймлосон лавлагааны цувралыг гол төлөв орчуулан хэвлэж байна. 2004 онд

- | Европын Холбоонд элсэх үйл явцыг хянах нь: Авиалгалтай тэмцэх бодлого
- | Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж зэрэг номыг хэвлэн олны хүртээл болголоо.




5.ОРЧУУЛГА, ХЭВЛЭН НИЙТЛЭЛИЙН ТӨСӨЛ

Нийгэм, эдийн засаг, улстөр, хөгжлийн сэдэвтэй, дэлхий нийтийн анхаарал татсан ном хэвлэлийг олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн монгол хэл рүү хөрвүүлэн шуурхай хүргэх, нийгмийн сэтгэлгээний хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор Нээлттэй Нийгэм Форумаас "Монсудар" хэвлэлийн газартай хамтран дараах номыг орчуулан хэвлэхээр тохиролцсон болно. Энэхүү үйл ажиллагааг "Монсудар" хэвлэлийн газар бүрэн хариуцаж, орчуулагч, редакторыг сонгон шалгаруулахдаа ННФ-ын зөвлөмж, туслалцааг авч ажиллахаар гэрээ байгуулсан байна.

Орчуулан хэвлэхээр тохирсон номын нэрс. Үүнд:

1. Майкл Фэйрбэнкс, Стэйс Линдсэй: **"Тэнгисийг хагалах нь: Хөгжиж буй дэлхий дэх далд нөөц баялагийг сэргээх нь"**
2. Фрэнсис Фукуяма: **"Төр улсаа төвхнүүлэхүй"**
3. Фрэнсис Фукуяма: **"Түүхийн төгсгөл буюу сүүлчийн хүн"**
4. Колин Робсон: **"Бодит ертөнцийн судалгаа"**
5. Карл Раймунд Поппер: **"Нээлттэй нийгэм ба түүний дайснууд"**
6. Айзак Азимов: **"Үүсэл: хүн төрөлхтөн, амьдрал, газар дэлхийн болон ертөнцийн түүх"**
7. Даниель Буурстин: **"Америк ардчиллын туршлага"**
8. Марис Дюверже: **"Төрийн байгууламж"**
9. Майкл Леснофф: **"ХХ зууны улстөрийн философичид"**
10. Самуэл Хантингтон: **"Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам"**
11. Жорж Оруел: **"1984 он"**



Тэрчлэн Монголын эдийн засгийн ирээдүйн сценари гаргах санаачилгын хүрээнд Монголын ирээдүйн зураглалыг боловсруулан "Гочоогийн дөрвөн тавилан" нэртэйгээр "Шинэ Эрин" сэтгүүлийн редакцитай хамтран тусгай дугаар болгон уншигч олонд хүргэлээ.

МОНГОЛЫН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭНГИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛСАН
БУСАД ХӨТӨЛБӨР



МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

МНХХ (Соросын сан)-аас өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн сүлжээний болон үндэсний хөтөлбөр төслийд нь Монголын боловсролын шинэчлэлийн үйл явцад тодорхой байр суурь, нэр хүндийг олж, энэ салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, улсын болон хувийн багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежуудын сургалтын хөтөлбөр, аргазүйг шинэчлэхэд чиглэсэн хөтөлбөр төслийд нь тухайн нэгж төвшний хэмжээнд амжилттай хэрэгжиж бодлогын төвшинд нөлөө үзүүлсэн юм. Тухайлбал, "Сургууль-2001", "Багш-2005", бага насны хүүхдийн хөгжлийн "Алхам алхмаар" хөтөлбөр, Хүүхэд залуучуудын "Мэтгэлцээн" хөтөлбөр, "Бүтээлч сэтгэлгээ", "Хууль бидний амьдралд" болон англи хэлний хичээлүүдийн сурх бичиг, МУИС-ийн Нийгмийн Ухааны сургалтын хөтөлбөрийг сайжруулах төсөл зэргийг нэрлэж болно. Сургалтын хөтөлбөр, аргазүйн шинэчлэлтэй уялдуулж сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх судалгааны төслийг БШСҮЯ-ны Боловсролын Үнэлгээний төв дээр 2004 оноос эхлэн хэрэгжүүлж, мэргэжлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ирэв. Тус төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын боловсролын системийг бусад улс орныхтой харьцуулах боломжийг бүрдүүллээ. Түүнчлэн сургуулийг хөгжүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Олон нийтийн оролцоот сургууль" төслийг 2004 оноос хэрэгжүүлж эхлэв.

Эдгээр хөтөлбөр нь Монголын боловсролын салбарын шинэчлэлд тодорхой үүрэг гүйцэтгэж, тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулсны зэрэгцээ боловсролын салбарынхны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, ололт амжилтыг бататгах, нөөц бололцоог дээшлүүлэх, хувь хүн болон байгууллагын чадавхийг нэгтгэсэн сүлжээ бий болгоход томоохон хувь нэмэр оруулсан юм.

Соросын сангийн сүлжээ нь олон улсын хэмжээнд хамтын ажиллагаа, хандивлагчдын оролцооны хүрээгээ улам бүр тэлж байгаатай холбогдуулан МНХХ нь хэрэгжүүлж ирсэн боловсролын хөтөлбөрүүдийнхээ шинэчлэлийн стратегийг дахин хянаж боловсруулах шаардлагатай болсон бөгөөд олсон амжилтдаа тулгуурлан 2004 оны зургадугаар сард МНХХ-гийн Удирдах зөвлөлийн хурлаар Боловсролын хөтөлбөрийг төрийн бус байгууллага болгон өөрчилж, Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /МБХАН/ байгуулагдсан юм.

МБХАН нь боловсролын салбар дахь нээлттэй нийгмийн үнэт зүйлийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулж, үндэсний болон олон улсын түнш байгууллагуудын сүлжээний тогтвортой ажиллагааг хангах, боловсрол эзэмших тэгш эрхийг хангах, ил тод байдал, иргэний нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг сайжруулах чиглэлээр шинэ төсөл, үйл ажиллагааг санаачилан хэрэгжүүлж байна.

БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

БЗМТ-ийн 2004 оны нийт зардал: \$70,835.55

БЗМТ-ийн хөтөлбөрийн зардал: \$57,856.79

ННХ-гийн тэтгэлэгт хөтөлбөрийн зардал: \$12408, 67
(2004 оны 8-р сарын 11-ээс 12-р сарын 31)

Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв (БЗМТ)-ийн эрхэм зорилго нь боловсрол, соёл хийгээд мэргэжлийн төрөл бурийн хөтөлбөрөөр дамжуулан байгууллага, хувь хүмүүсийн хооронд харилцан ойлголцол, урт хугацааны хэлхээ холбоо тогтоох; Монголоос гадаадад суралцагсдын тоог нэмэгдүүлэх; залуу хүмүүст гадаадад сурч боловсрох нөхцөл, боломжийн талаарх мэдээллийг нээлттэй, ижил тэгш байдлаар хүргэх, гадаадын их, дээд сургууль хайж олох, коллежийн элсэлтийн шалгалтад бэлтгэхэд тэдэнд удирдамж, зөвлөгөө өгөх замаар өрнөдийн мэдлэгийг Монголын нийгмийн бүх салбарт нэвтрүүлэх явдал юм.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

2004 онд Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв нь тэтгэлэгт хөтөлбөр, гадаадад суралцах хүсэлтэй оюутан, сурагчдын мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилготой хэд хэдэн цуврал хөтөлбөр боловсруулж хэрэгжүүллээ. Энэ хугацаанд тус төвийн номын санг ашиглагчдын тоо өмнөх жилийнхээс 48 хувь, лекцэд оролцогчдын тоо 18 хувиар өссөн байна. Тэрчлэн 1200 гаруй хүмүүст гадаадад суралцах боломжийн талаар багц зөвлөгөө, 864 хүнд ганцаарчилсан зөвлөгөө өглөө. Улаанбаатар хот дахь Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвөөр дамжин холбоо тогтоосон оюутны тоо 59386 байгаа бол салбар төвүүдийн тоотой нийлээд 83914 болж байна.

Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн үйл ажиллагаа өндөрлөсний дараа Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Сүлжээний Тэтгэлэгт Хөтөлбөрүүд, Төв Европын Их Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр, мөн сургуулийн тусгай,



өргөтгөсөн тэтгэлэгт хөтөлбөрүүд, тэрчлэн дээд боловсролыг дэмжих хөтөлбөрүүдийг 2004 оны наймдугаар сараас Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвд шилжүүлсэн юм. Иймд БЗМТ нь эдгээр хөтөлбөрийг санхүү, зохион байгуулалтын хувьд удирдан хэрэгжүүлж ирэв. Улаанбаатар дахь манай төв нь орон нутагт салбар төвүүд байгуулан үйл ажиллагаагаа өргөтгөснөөр тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг хүсч өргөдөл гаргасан хүмүүсийн тоо 2004 онд 50 хувиар өслөө.

2004 онд Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв хоёр төсөл дээр ажилласны нэг нь "Монголын боловсролын зөвлөгөө, Тестийн үйлчилгээний сүлжээг цаашид хөгжүүлэх" нэртэй боловсролын тестийн үйлчилгээний төсөл байв. Уг төслийн зорилго нь боловсролын мэдээллийг улс даяар түгээх үйлчилгээг эрхэлж буй Боловсролын зөвлөгөө, тестийн төвүүдийн сүлжээнд шилжүүлэх замаар Улаанбаатар хот дахь БЗМТ болон түүний орон нутаг дахь салбар төвүүдэд байгаа гадаадад суралцах боломжийн талаарх мэдээлэл хангамжийг улам нэмэгдүүлэх зорилт байлаа. Төсөл хэрэгжүүлэх явцад манай дөрвөн төв "Нээлттэй өдрүүд" зохион байгуулж, өргөн олныг хамрах тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Нээлттэй өдрүүдээр нийт 5320 хүн оролцсоноос гадна тусгай хөтөлбөрүүдэд хамрагдсан оюутан, сурагчдын тоо 2100-д хүрсэн нь 2003 онтой харьцуулахад 50 хувиар өсчээ.

Улаанбаатар хотын Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвд албан бус ТОЕФЛ-ийн шалгалтыг найман удаа, Дархан, Эрдэнэт хотод гурван удаа зохион байгуулж, нийт 96 хүнийг хамруулсан бөгөөд шалгалтад хамрагдагсдын дундаж оноо 478 байв. Үндэсний телевизийн "Үдшийн хэмнэл" нэвтрүүлгээр 11 удаа, "Оюутан" сониноор мөн 11 нийтлэл хэвлэн нийтэлж, гадаадын их, дээд сургуулийн хаягаар хайлт хийх, элсэлтийн дүрэм, журам, элсэлтийн өргөдөл бичихэд тавигдах шаардлага, элсэлтийн шалгалтууд болон Америкийн коллеж, их дээд сургуулийн сургалтын талаар мэдээлэл өгсөн болно.

Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвийн хоёрдахь төсөл нь МНХХ-гийн санхүүжилттэй "Монголын оюутнуудад зориулсан дадлагын ажил" төсөл бөгөөд хоёр жилийн хугацаатай уг төслийн гол зорилго нь оюутнуудад ажлын дадлага, чадвар олгож, тэдэнд суралцах үеэс нь төрөл бүрийн албан байгууллагатай түншлэлийн харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх явдал байв. Тэтгэлэгийн нэг хэсгийг салбар төвүүдэд шилжүүлж, төсөлд оролцуулсан болно. Оюутны дадлагын ажлын талаар Монголын болон бусад улсын туршлагаас судалж, төслийн баримт бичиг боловсруулж, дадлагын оюутан авах сонирхолтой байгууллагууд, дадлага хийх сонирхолтой оюутнуудын талаар мэдээллийн сан бий болгов. Оюутны дадлагын ажлыг 2004 оны зүн эхлүүлсэн бөгөөд одоогоор тус төв дадлагын ажлын мэдээллийн санг төвийнхөө вэб хуудсанд тавихаар ажиллаж байна.

2004 оны дөрөвдүгээр сард Олон Улсын Боловсролын Яармагт оролцож, 11000 гаруй хүнд мэдээллээ түгээсний дээр 11 дүгээр сард Монголд анх удаа тэтгэлэгт сургалтын анхны үзэсгэлэнг зохион байгуулав. Энэхүү үзэсгэлэнд 22 байгууллага оролцож, 4000 орчим хүн үзэсгэлэнг үзэж сонирхлоо.

БАЙГУУЛЛАГУУДАД ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ

№	Тэтгэлгийн нэр	Олгосон байгууллага	Тэтгэлгийн зорилго	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр			
					Дотоод	Сүлжээ	Бусад	Бүгд
1	Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв (БЗМТ), Ховд аймаг	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын боловсрол, соёлын хэлтэс	БЗМТ-ийн салбарыг Ховдод нээж, сурч боловсрох боломжийн талаарх мэдээллийг илүү чөлөөтэй олж авах нөхцлөөр хангах ажиллагааг нь дэмжих	2004	--	--	\$1560	\$1560
2	Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв (БЗМТ), Дархан Уул аймаг	Дархан Уул аймгийн нийтийн номын сан	БЗМТ-ийн Дархан Уул аймаг дахь үйл ажиллагааг дэмжих, Боловсролын тестийн үйлчилгээ, оюутны дадлагын ажлын хөтөлбөр хэрэгжүүлэх	2004	\$550	--	\$438	\$988
3	Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв (БЗМТ), Орхон аймаг	Орхон аймгийн Номын Төв	БЗМТ-ийн Эрдэнэт дэх үйл ажиллагааг дэмжих, Боловсролын тестийн үйлчилгээ, оюутны дадлагын ажлын хөтөлбөр хэрэгжүүлэх	2004	\$550	--	\$300	\$850
4	Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв (БЗМТ), Ховд аймаг	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын боловсрол, соёлын хэлтэс	Боловсролын тестийн үйлчилгээ, оюутны дадлагын ажлын хөтөлбөр хэрэгжүүлэх	2004	\$400	--	\$50	\$450



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НИЙГЭМЛЭГ

Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөр нь 2004 онд Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийн сайтар мэргэшсэн ажиллах хүчин бэлтгэх ажилд голлон анхаарч, төгсөлтийн дараах сургалтын агуулга, чанарыг сайжруулах, багш нарын чадавхийг дээшлүүлэх, эмч нар, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд ўйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Нийгмийн эрүүл мэндийн салбарын ажиллах хүчинийг бэлтгэх санаачилгын дор тус хөтөлбөрөөс ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн нийгмийн эрүүл мэндийн магистрын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг үргэлжлүүлэн олон улсын жишигт хүрсэн сургалтын шинэ хөтөлбөр боловсруулж, мастериyn сургалтыг олон улсын жишигт хүргэх, гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах замаар багшлах хүчин чадавхийг бэхжүүлэх, сургалтад хамрагдсан багш, оюутны эрдэм шинжилгээний чадавхийг дээшлүүлэх зорилгоор багавтар төслүүдийг дэмжих ажилласан болно.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг анхан шатны байгууллагууд дээр хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн анхны тусалцаа үзүүлэгчдэд зориулсан давтан сургалтын модулийг боловсрууллаа. Тэрчлэн багш нарын үндсэн багийг бэлтгэж, сургалтын сурх бичгийг монгол хэлээр боловсрууллаа. Нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах сэдвээр хилийн чанадад болсон ННХ-гийн нийгмийн эрүүл мэндийн бага хурал, зөвлөгөөнд дөрвөн хүнийг оролцуулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Зальцбургийн залуу эмч нар зориулсан семинарт Монголын 19 эмчийг оролцуулж, анагаах ухааны тодорхой салбарын болон эмнэлгийн орчин үеийн мэдлэг, мэдээлэл олголоо.

2004 онд тус хөтөлбөрийн хийсэн нэг чухал ажил нь МННХ энэ оны наймдугаар сард үйл ажиллагаагаа зогсоосонтой холбогдуулан урьд өмнө хэрэгжүүлсэн тэтгэлэгт хөтөлбөрүүдийг түшиц газартай болгож, цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор хөтөлбөрийг Монголын Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг (МНЭММН)-т шилжүүлсэн явдал юм. Энэ нийгэмлэг нь өнгөрсөн хугацаанд МННХ-гийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд хөтөлбөр боловсруулах болон шийдвэр гаргах ажилд мэргэжлийн зөвлөгөө өгч идэвхтэй оролцож ирсэн бөгөөд Монголын нийгмийн эрүүл мэндийн салбарт хандивлагч байгууллагуудын дунд нэр хүнд сайтай, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах ихээхэн туршлага, сонирхолтой байгууллага юм.

Хөтөлбөрийг МНЭММН-т шилжүүлэх нь дараах зорилготой байв. Үүнд:

1. Хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг түшиц газартай болгож, цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд тус нийгэмлэгийн арга, туршлагыг ашиглах
2. Нийгэмлэгийн зохион байгуулалт, чадавхи, имижийг бэхжүүлэх
3. ННХ-гийн Нийгмийн эрүүл мэндийн сүлжээний хөтөлбөрүүд, МНЭММН-ийн хооронд цаашдын хамтын ажиллагааны харилцаа, холбоог сайжруулах зэрэг болно.



ДОРНО-ДОРНО ХӨТӨЛБӨР

Дорно-Дорно: Хил Хязгааргүй Түншлэл хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлж бэхжүүлэхэд чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хүчин чармайлтыг нэгтгэх, шинэлэг бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааны урт хугацааны үр ашигтай түншлэлийг бий болгохыг дэмждэг.

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Тус хөтөлбөр нь 2004 онд иргэний нийгмийн байгууллагууд бусад орны ижил төрлийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож урт хугацааны хамтын ажиллагааны эхлэл тавих, тэдгээрийн туршлагыг судалж өөрийн үйл ажиллагаандaa нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Тухайлбал:

- I. Монгол Улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх, тусгай хууль батлуулахын төлөө хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд 10 гаруй жил идэвхтэй, тууштай үйл ажиллагаа явуулж ирсэн. ТББ-үүд уг хуулийн төсөл дээр ажиллах ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд 2002 оны 11 дүгээр сард УИХ-ын дэргэд Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан нь уг асуудлыг хууль тогтоох төвшинд анхаарч эхэлсний илрэл болсон юм. Иймд Дорно Дорно хөтөлбөр нь Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль, түүний хэрэгжилтийн талаарх Малайз улсын туршлагаас судлах аяллыг 2004 оны нэгдүгээр сарын 24-31-нд хооронд Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтран зохион байгууллаа.

Энэхүү танилцах аяллын үр дунд:

1. Хуулийг батлах бүрэн эрх бүхий УИХ-ын дөрвөн гишүүн, хуулийн хэрэгжилтэд голлох үүрэгтэй оролцох Шүүх, Цагдаа, Прокурорын болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон 12 хүний бүрэлдэхүүнтэй багийн гишүүд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай хууль батлан хэрэгжүүлэхийн ач холбогдолын талаарх бодит төсөөллөө баяжуулж, гэр бүлийн хүчирхийллийн асуудалд хандах хандлага нь уг хуулийг бодитой хэрэгжүүлж байгаа улс оронд хэрхэн өөрчлөгдж байгаатай танилцаа.
2. Оролцогчид Малайзын Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн давуу болон сул тал, хууль хэрэгжих явцад гарч буй хүндрэлүүд, тэдгээрийг даван туулж буй арга зам, бие даасан хууль батлахын давуу тал, хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, зөвлөгөө, сэтгэлзүйн засал зэрэгтэй танилцсанаар хуулийн төслийг улам сайжруулах тодорхой санал боловсруулсан юм. Тэрчлэн энэ асуудлаар бие даасан хууль гаргахад шүүмжлэлтэй хандаж байсан зарим гишүүний хандлага өөрчлөгдсөн байна.

3. Хууль тогтоогчид, олон нийт рүү хандсан нөлөөллийн ажиллагааг эрчимтэй явуулав.
 4. Энэхүү туршлага судлах аялал нь хууль батлуулахад болон хуулийн хэрэгжилтэд чухал тулхэц үзүүлсэн юм. Энэ бүхний үр дунд Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль нь Монгол Улсын Их Хурлаар 2004 оны тавдугаар сарын 13-ны өдөр батлагдав.
- II. Хууль батлагдсаны дараа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг Төв Азийн орнуудын форумын анхны хуралдааныг Консенсус төвөөс зохион байгуулахад Дорно Дорно хөтөлбөр туслалацаа дэмжлэг үзүүлэв. Чуулга уулзалтын үеэр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар бус нутгийн хэмжээнд хамтын түншлэлийг хөгжүүлэх боломжийг тодорхойлж, цаашдын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсаны зэрэгцээ Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг Төв Азийн сүлжээг байгуулж дүрмийг баталсан байна.
- III. Монголын Урлагийн Зөвлөлөөс санаачилсан «Төв, Зүүн Өмнөд Ази болон Монгол дахь соёлын аялал, жуулчлалын түншлэл» олон улсын зөвлөгөөнийг 2004 оны 10 дугаар сарын 21-22нд зохион байгуулав. Монголд соёлын аялал, жуулчлалыг хөгжүүлэхдэд төр, олон нийтийн байгууллага, бизнесийн салбарын хамтын ажиллагааг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд шинэлэг хэлбэрээр өргөжүүлэх, улмаар соёлын аялал, жуулчлалаар дамжуулан улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахын тулд энэ салбарт үр бүтээлтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж, арга замыг эрэлхийлэх нь уг уулзалт зөвлөгөөний гол зорилго байлаа.




Тус зөвлөгөөнөөр Төв болон Зүүн Өмнөд Ази, Хойд Америк дахь соёлын аялал, жуулчлалын чиг хандлага, аялал жуулчлал ба соёл, урлагийн салбарын түншлэлийн олон улсын тэргүүн туршлага, ядуурлыг бууруулах, үндэсний эдийн засгийн өсөлт, түүх, соёлын өвийг хадгалан хамгаалахад соёлын аялал, жуулчлалын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө, Монгол болон Төв, Зүүн Өмнөд Азид энэхүү аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг өргөн хүрээнд хэлэлцсэн юм. Хэлэлцсэн асуудлууд, оролцогчдоос гаргасан санал, санаачилгад үндэслэн соёлын аялал, жуулчлалын Үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг түншлэлийн түвшинд дэмжиж болох зарим арга замыг сувэгчилсэн зөвлөмж боловсруулан энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг төр, олон нийт, бизнесийн байгууллага, урлаг соёлын ажилтууд, бодлого боловруулагчдад хүргүүлэв. Соёлын аялал, жуулчлалын түншлэлийг хөгжүүлэх зорилгоор дотоод, гадаадын байгууллага, төлөөлөгчдөөс бүрдсэн «Соёлын Аялал, Жуулчлалын Зөвлөл»-ийг байгуулахаар шийдвэрлэсэн юм.

Дорно Дорно хөтөлбөр нь 2004 онд гадаад орнуудад зохиогдсон олон улсын чуулга уулзалт, бага хурал, семинарт оролцох хүмүүст мөн тэтгэлэг



олгосон юм. Ингэснээр дээрх хүмүүст мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, олсон мэдлэгээ хамт олонтойгоо хуваалцах, гадаадын мэргэжил нэгт хүмүүстэй харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах боломж олгосон болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Зардал (хөтөлбөрөөр)**

Нийт зарцуулалт (төрлөөр)

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
Засаглал			
Мэдээллийн эрх чөлөө	3 889	800	4 689
Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүрэг	11 702	24 461	36 163
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт	45 930	3 596	49 526
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	-	3 735	3 735
Нээлттэй, ил тод төсөв	-	4 116	4 116
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	33 635	7 930	41 565
Эрхзүйн туслалцаа	32 807	18 952	51 759
Мэдээлэл холбооны технологийн бодлого	18 000	3 046	21 046
Ил тод байдал	9 932	2 117	12 049
Эдийн засгийн хөгжлийн бодлого			
Сүүдэр эдийн засгийн үүрэг	81 755	2 397	84 152
Бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй	-	16 874	16 874
Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж	-	31 877	31 877
Нийгмийн асуудлууд			
Нийгмийн салбарын хувьчлал	-	14 132	14 132
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	9 294	5 948	15 242
ННФ-ын бусад төслүүд			
Хөгжлийн мэдээллийн төв	-	56 748	56 748
Телевизийн хөтөлбөр	-	435 314	435 314
Портал сайт	-	56 398	56 398
Олон нийтийн хэлэлцүүлэг	-	126 248	126 248
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	-	21 852	21 852
Хэвлэн нийтлэл	22 393	81 369	103 762
ННФ-ын захиргаа			
Мэргэжил дээшлүүлэх сургалт	-	11 251	11 251
ННФ-ын захиргаа	-	189 250	189 250
Нээлттэй Нийгэм Форум			
Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	-	17 989	17 989
Эмэгтэйчүүд	17 127	8 002	25 129
Дорно дорно	51 787	20 543	72 330
Мэдээлэл	15 942	112 873	128 815
Бусад хөтөлбөр			
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэг	256 857	12 015	268 872
Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	61 586	11 356	72 942
Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	515 484	108 296	623 780
МННХ-гээс бие даан гарсан хөтөлбөрүүд			
МННХ-ийн захиргаа	-	200 847	200 847
МННХ-гийн захиргаа			
Нийт дүн	1 188 120	1 610 331	2 798 451

**Нийт зарцуулалт (Санхүүгийн эх үүсвэрээр)**

\$ доллар

Хөтөлбөр	Сүлжээнээс	Үндэсний сангаас	Бусад	Нийт зардал
Засаглал				
Мэдээллийн эрх чөлөө	-	4 689	-	4 689
Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүрэг	-	36 163	-	36 163
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт	-	49 526	-	49 526
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт	-	3 735	-	3 735
Нээлттэй, ил тод төсөв	-	3 396	720	4 116
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	41 565	-	-	41 565
Эрхзүйн туслалцаа	35 310	16 449	-	51 759
Мэдээлэл холбооны технологийн бодлого	13 000	8 046	-	21 046
Ил тод байдал	-	12 049	-	12 049
Эдийн засгийн хөгжлийн бодлого				
Сүүдэр эдийн засгийн үүрэг	-	84 152	-	84 152
Балчээрийн мал аж ахуйн ирээдүй	-	16 874	-	16 874
Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж	-	16 209	15 668	31 877
Нийгмийн асуудлууд				
Нийгмийн салбарын хувьчлал	-	14 132	-	14 132
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	-	15 242	-	15 242
ННФ-ын бусад төслүүд				
Хөгжлийн мэдээллийн төв	-	56 748	-	56 748
Телевизийн хөтөлбөр	-	435 314	-	435 314
Портал сайт	-	56 398	-	56 398
Олон нийтийн хэлэлцүүлэг	-	126 248	-	126 248
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	21 852	-	-	21 852
Хэвлэн нийтлэл	20 000	83 762	-	103 762
ННФ-ын захиргаа				
Мэргэжил дээшлүүлэх сургалт	-	11 251	-	11 251
ННФ-ын захиргаа	-	189 250	-	189 250
Нээлттэй Нийгэм Форум	131 727	1 239 632	16 388	1 387 747
Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	6 442	11 547	-	17 989
Эмгэгтийчүүд	8 564	16 565	-	25 129
Дорно дорно	50 328	20 542	1 460	72 330
Мэдээлэл	38 352	90 463	-	128 815
Бусад хөтөлбөр	103 685	139 117	1 460	244 263
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэг	155 179	113 693	-	268 872
Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	37 984	11 969	22 989	72 942
Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	107 574	504 542	11 664	623 780
МННХ-гээс бие даан гарсан хөтөлбөрүүд	300 737	630 204	34 653	965 594
МННХ-ийн захиргаа	1 110	199 421	316	200 847
МННХ-гийн захиргаа	1 110	199 421	316	200 847
Нийт дүн	537 259	2 208 374	52 817	2 798 450

2004 онд байгууллагад олгосон тэтгэлэг

Тэтгэлэгийн зориулалт	Тэтгэлэг авагч	Хугацаа		Сүлжээнээс	Үндсэн сангаас	Бусад	Нийт
Сонгуулийн студи төсөл	TI - Mongolia	2004 оны 6-7 сар	Төрийн бус		7 865		7 865
Газрын шинэтгэлийн мониторинг	Төв Европын Их Сургууль	2004 оны 2-3 сар	Төрийн бус		3 889		3 889
Эрх чөлөө ба шударга	Globe International	2004 оны 5-6 сар	Төрийн бус		11 702		11 702
Сонгуулийн санхүүжилтийн мониторинг	Globe International	2004 оны 3-8 сар	Төрийн бус		45 930		45 930
Газрын шинэтгэлийн мониторинг	Байгаль XXI	2004 оны 4 сар-2005 оны 4 сар	Төрийн бус		31 532		31 532
Өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төв	Хууль Зүй Дотоод Хэргийн Яам	2004 оны 4-10 сар	Төрийн		8 383		8 383
“Хуульзүйн туслалцааг хэрхэн авах вэ” гарын авлага	Хүмүүнлэг Клиник	2004 оны 12 сар-2005 оны 3 сар	Төрийн бус		6 082		6 082
Стратеги өмгөөллийг хэрхэн хийх вэ гарын авлага	Хүний эрх, хөгжил төв	2004 оны 12 сар	Төрийн бус		13 260		13 260
ХӨТӨЛБӨР Засаглал					128 643	-	128 643
Сүүдрийн эдийн засгийн үүрэг	Статистикийн Төв Газар	2004 оны 4-10 сар	Төрийн		81 755	-	81 755
ХӨТӨЛБӨР Эдийн засгийн хөгжлийн бодлого					81 755	-	81 755
Залуу судлаачдын үндэсний анхдуугаар форум	Нээлттэй Академи	2004 оны 10 сар-2005 оны 1 сар	Төрийн бус		1 000		1 000
ХӨТӨЛБӨР Нийгмийн асуудлууд					1 000	-	1 000
Ардчилсан засаглал							



ба нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь	Улс Төр Боловсролын Академи	2004 оны 6-10 сар	Төрийн бус		11 113		11 113
Ардчилсан засаглал ба нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь /нэмэлт тэтгэлэг/	Улс Төр Боловсролын Академи	2005 оны 1-12 сар	Төрийн бус		3 180		3 180
Зүүн Азийн Барометр гарын авлага	Улс Төр Боловсролын Академи	2004 оны 1-6 сар	Төрийн бус		3 100		3 100
ХӨТӨЛБӨР ННФ-ийн бусад хөтөлбөр				17 393	-	17 393	
ХӨТӨЛБӨР Нээлттэй Нийгэм Форум				228 791	-	228 791	
Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төв	Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төв	2004 оны 8 сар- 2007 оны 8 сар	Төрийн бус	14 552	7 842	16 989	39 383
ХӨТӨЛБӨР Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төв				14 552	7 842	16 989	39 383
Олон нийтийн оролцоот сургууль	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Дархан-Уул аймгийн 9-р сургууль	2004 оны 1-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Говьсүмбэр аймгийн 2-р сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Дорнод аймгийн 1-р сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100

Олон нийтийн оролцоот сургууль	Архангай аймгийн Чулуут сумын сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		5 100		5 100
Олон нийтийн оролцоот сургууль	Архангай аймгийн Тариат сумын сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		1 700		1 700
Олон нийтийн оролцоот сургууль	Улаанбаатар хотын 58-р сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		1 700		1 700
Олон нийтийн оролцоот сургууль	Улаанбаатар хотын 16-р сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		1 700		1 700
Нээлттэй хэлэлцүүлэг	Орхон аймгийн Эрдэм Төв ТББ	2004 оны 4-12 сар	Төрийн	2 300			2 300
Нээлттэй хэлэлцүүлэг	Арга Эв ТББ	2004 оны 4-12 сар	Төрийн бус	1 725	575		2 300
Нээлттэй хэлэлцүүлэг	Хөвсгөл аймгийн Далай Ван коллеж	2004 оны 4-12 сар	Төрийн	2 300			2 300
Нээлттэй хэлэлцүүлэг	Залуу үе ТББ	2004 оны 4-12 сар	Төрийн бус	2 30			2 300
Нээлттэй хэлэлцүүлэг	Хүүхэд залуучуудын Санаачилга	2004 оны 4-12 сар	Төрийн бус		2 300		2 300
Олон нийтийн оролцоот сургууль	Дархан-Уул аймгийн 15-р сургууль	2004 оны 4-12 сар	Төрийн		1 700		1 700
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр арга зүйн шинэчлэл	БИС-ын Боловсрол Судлалын Сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	Дорнод аймгийн багшийн коллеж	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200



Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	Их Монгол их сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	Гурван Эрдэнэ багшийн их сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	БИС-ийн компьютер мэдээллийн технологийн сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	БИС-ийн Нийгмийн ухааны дээд сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн	900	900		1 800
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	МУИС-ийн Монгол хэл Соёлын сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	Нийгмийн ухааны дээд сургууль	2004 оны 3-6 сар	Төрийн		2 200		2 200
Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр аргазүйн шинэчлэл	Улаанбаатар хотын багшийн коллеж	2004 оны 3-6 сар	Төрийн	900	900		1 800
МНХХ-гийн боловсролын хөтөлбөр	Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	2004 оны 8 сараас	Төрийн бус	62 736	353 235	8 658	424 629
ХӨТӨЛБӨР	Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг			73 161	415 810	8 658	497 629
Шинэ НЭМ-ийн суурь сургалтын модуль боловсруулах	Эмнэлгийн тусlamжийг удирдах газар	2004 оны 4 сар-2005 оны 4 сар	Төрийн	7 097	29 589		36 686

МННХ-гийн НЭМ хөтөлбөр	Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтний Нийгэмлэг	2004 оны 8 сараас	Төрийн бус	132 941	68 144		201 085
ХӨТӨЛБӨР	Нийгмийн Эрүүл Мэндийн Мэргэжилтний Нийгэмлэг	140 038	97 733	-	237 771		
ХӨТӨЛБӨР	МННХ-гээс бие даан гарсан хөтөлбөрүүд	227 751	521 385	25 647	774 783		
Эр хүн эр хүндээ	Amnesty International Mongolia	2004 оны 3 сар 2005 оны 3 сар	Төрийн бус	8 564	8 564		17 127
ХӨТӨЛБӨР	Эмэгтэйчүүд		8 564	8 564	-	17 127	
Малайзид Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хуулийн хэрэгжилтэй танилцах аялал	Хуульч Эмэгтэй- чүүдийн Холбоо	2004 оны 1 сар	Төрийн бус	16 553			16 553
Гэр бүлийн хүчирхий- лэлийн эсрэг Төв Азиин анхдугаар форум	Consensus center	2004 оны 5-6 сар	Төрийн бус	14 525			14 525
Соёлын аялал жуучлалын түншлэл	Монголын Урлагийн Зөвлөл	2004 оны 10-11 сар	Төрийн бус	6 955			6 955
ХӨТӨЛБӨР	Дорно Дорно		38 033	-	-	38 033	
Нээлттэй мэдээллийн төв	Нээлттэй мэдээллийн төв	2004 оны 5 сар	Төрийн бус		5 844		5 844
ХӨТӨЛБӨР	Мэдээлэл		5 844	-	5 844		
ХӨТӨЛБӨР	ННФ-ийн бусад хөтөлбөр		46 596	14 408	-	61 004	
Нийт дүн			274 347	764 584	25 647	1 064 578	

**Нийт зарцуулалт (төрлөөр)**

\$ доллар

Хөтөлбөр	Хувь хүн	ТББ	Төрийн байгууллага	Нийт зардал
<u>Засаглал</u>				
Мэдээллийн эрх чөлөө		3 889		3 889
Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүрэг		11 702		11 702
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт		45 930		45 930
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт				-
Нээлттэй, ил тод төсөв				-
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	2 103	31 532		33 635
Эрхзүйн туслалцаа		19 342	8 383	27 725
Мэдээлэл холбооны технологийн бодлого	18 000			18 000
Ил тод байдал	2 067	7 865		9 932
<u>Эдийн засгийн хөгжлийн бодлого</u>				
Сүүдэр эдийн засгийн үүрэг			81 755	81 755
Бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй				-
Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж				-
<u>Нийгмийн асуултууд</u>				
Нийгмийн салбарын хувьчлал		1 000		1 000
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	8 294			8 294
<u>ННФ-ын бусад төслийн төв</u>				
Хөгжлийн мэдээллийн төв				-
Телевизийн хөтөлбөр				-
Портал сайт				-
Олон нийтийн хэлэлцүүлэг				-
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр				-
Хэвлэн нийтлэл	5 000	17 393		22 393
<u>ННФ-ын захиргаа</u>				
Мэргэжил дээшлүүлэх сургалт				-
ННФ-ын захиргаа				-
Нээлттэй Нийгэм Форум	35 46	138 653	90 138	264 255
Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	5 082			5 082
Эмэгтэйчүүд		17 127		17 127
Дорно дорно	9 110	38 033		47 143
Мэдээлэл	14 742	5 844		20 586
Бусад хөтөлбөр	28 934	61 004	89 938	
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэг	19 086	201 085	36 686	256 857
Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	22 204	39 382		61 586
Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	17 855	431 529	66 100	515 484
МННХ-ээс бие даан гарсан хөтөлбөрүүд	59 145	671 996	102 786	833 927
Нийт дүн	123 543	871 653	192 924	1 188 120

Нийт зарцуулалт (Тэтгэлэгийн тоогоор)

\$ доллар

Хөтөлбөр	Сүлжээнээс	Үндэсний сангаас	Бусад	Нийт зардал
<u>Засаглал</u>				
Мэдээллийн эрх чөлөө		3 889		3 889
Сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн гүйцэтгэх үүрэг		11 702		11 702
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт		45 930		45 930
Төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт				
Нээлттэй, ил тод төсөв				
Газрын шинэтгэлийн хэрэгжилт	33 635			33 635
Эрхзүйн туслалцаа	27 725			27 725
Мэдээлэл холбооны технологийн бодлого	18 000			18 000
Ил тод байдал	9 932			9 932
<u>Эдийн засгийн хөгжлийн бодлого</u>				
Сүүдэр эдийн засгийн үүрэг	81 755			81 755
Бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй				
Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж				
<u>Нийгмийн асуудлууд</u>				
Нийгмийн салбарын хувьчлал	1 000			1 000
Боловсролын салбарын төсвийн зарцуулалт	8 294			8 294
<u>ННФ-ын бусад төслүүд</u>				
Хөгжлийн мэдээллийн төв				
Телевизийн хөтөлбөр				
Портал сайт				
Олон нийтийн хэлэлцүүлэг				
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр				
Хэвлэн нийтлэл	22 393			22 393
ННФ-ын захиргаа				
Мэргэжил дээшлүүлэх сургалт				
<u>ННФ-ын захиргаа</u>				
Нээлттэй Нийгэм Форум		264 255		264 255
Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	5 082			5 082
Эмэгтэйчүүд	8 564	8 564		17 127
Дорно Дорно	45 683		1 460	47 143
Мэдээлэл	7 982	12 604		20 586
Бусад хөтөлбөр		67 311	21 168	1 460
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийгэмлэг	153 332	103 525		256 857
Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	27 984	8 774	24 829	61 586
Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	89 595	416 232	9 657	515 484
МННХ-ээс бие даан гарсан хөтөлбөрүүд		270 911	528 531	34 486
Нийт дүн		338 222	813 954	35 946
				1 188 120



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Т.Галбаатар
Д.Жаргалсайхан
Саха Meyanathan
Ж.Нарантүяа
Ц.Ариуннаа
П.Цэнгүүн
Л.Төр-Од

tgalbaatar@magicnet.mn
djargal@yahoo.com
smeyanathan@worldbank.org
narantuya@mail.parl.gov.mn
ariunaa@arts council.mn
ptsenguun@altantaria.mn
turod@undp.org

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.Эрдэнэжаргал

jargal@soros.org.mn

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН АЖИЛТНУУД

М.Амарбаяр	TV хөтөлбөрийн редактор	amarbayar@soros.org.mn
Д.Аюуш	Нягтлан бодогч	ayush@soros.org.mn
Г.Азжаргал	TV хөтөлбөрийн техникийн ажилтан	azaa@soros.org.mn
Р.Бадамрагчаа	ННФ-ын захирлын туслах	badmaa@soros.org.mn
Д.Балжид	Мэдээллийн төвийн менежер	baljid@soros.org.mn
Т.Батбаатар	Веб мастер	batbaatar@soros.org.mn
Ж.Баярцэцэг	ННФ-ын менежер	bayar@soros.org.mn
Г.Биндерьяа	ННФ-ын туслах ажилтан	binderya@soros.org.mn
Н.Дорждарь	ННФ-ын менежер	dorjdar@SOROS.org.mn
Д.Энхбат	TV хөтөлбөрийн захирал, хөтлөгч	jjilmurun@soros.org.mn
Ц.Ижилмөрөн	Мэдээлийн төвийн туслах ажилтан	gantuya@soros.org.mn
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	ganbold@soros.org.mn
Ц.Ганболд	TV хөтөлбөрийн ерөнхий менежер	gerelmaa@soros.org.mn
А.Гэрэлмаа	ННФ-ын менежер	javkhilan@soros.org.mn
Д.Жавхлан	Санхүүгийн захирал	ichka@soros.org.mn
Б.Ичинхорлоо	ННФ-ын туслах ажилтан	soyoloo@soros.org.mn
Б.Мөнхсоёл	ННФ-ын менежер	naraa@soros.org.mn
Б.Нарантуяа	TV хөтөлбөрийн менежер	onon@soros.org.mn
Р.Оон	ННФ-ын менежер	tsog@soros.org.mn
Ш.Цог	Порталын англи хэлний редактор	tseren@soros.org.mn
Д.Цэрэнжав	TV хөтөлбөрийн редактор	ulzii@soros.org.mn
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	reception@soros.org.mn
Т.Отгонбаяр	Захиргааны туслах ажилтан	saruul@soros.org.mn
Ч.Саруул	Жолооч	baatar@soros.org.mn
Б.Баатар	Жолооч	cedev@soros.org.mn
Г.Цэдэвхүү	Жолооч	

Нийтлэг Имэйль :

osf@soros.org.mn



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ



АРТ имПРЕСС ХХК-д

Ерөнхий сайд Амарын гудамж. Соёлын төв өргөө "Г" байр 416 тоот өрөө. Утас: 91147411